МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 09 сарын 26 өдөр Дугаар А/305 Улаанбаатар хот

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих
туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх
удирдамж шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоол, 2019 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж"-ийг нэгдүгээр, "Мэргэжлийн сургалтын байгууллагатай байгуулах үр дүнд суурилсан санхүүжилтийн гэрээний загвар"-ыг хоёрдугаар, "Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтад хамрагдах тухай гэрээний загвар"-ыг гуравдугаар, "Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажиллах тухай гурван талт гэрээний загвар", "Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах, суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулах, ажлын байраар хангахад хамтран ажиллах тухай гурван талт гэрээний загвар"-ыг дөрөвдүгээр, "Нийслэлд зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын мэргэжлийн сургалтын чиглэл, хугацаа, нэг суралцагчид ногдох зардлын дээд хэмжээ", "Аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын мэргэжлийн сургалтын ерөнхий чиглэл, нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ"-г тавдугаар, "Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын бусад зардлын жишиг хэмжээ"-г зургаадугаар, "Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт төгсөгчийн чадамжийн үнэлгээний төлбөрийн хэмжээ"-г долоодугаар, "Зээлийн дараах санхүүгийн бус дэмжлэгийг хариуцан гүйцэтгүүлэх тухай гэрээний загвар"-ыг наймдугаар, "Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх тухай гурван талт гэрээний загвар"-ыг есдүгээр, "Жижиг зээл авсан иргэдэд зориулсан санхүүгийн бус үйлчилгээний жишиг зардал"-ыг аравдугаар, "Орон нутгийн санаачилгын төсөл хэрэгжүүлэх тухай гэрээний загвар"-ыг арван нэгдүгээр, "Олон Улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон Улсын Хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдэд залилан, авилгаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох тухай удирдамж"-ийг арван хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу шаардлагатай тайлангийн маягтуудыг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Б.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбоотойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж батлах тухай" 2018 оны А/281 дугаар тушаал, "Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чиглэл, хугацаа, нэг суралцагчид ногдох зардлын дээд хэмжээг шинэчлэн батлах тухай" 2019 оны А/154 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.НИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 39 дүгээр сарын
26-ны өдрийн 1/ дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж

Нэг. Зорилго

1.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 2-р тогтоолоор баталсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр" (ХЗЗДТХ)-ийг нэгдсэн зохион байгуулалттайгаар, үр дүнтэй хэрэгжүүлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд, сум, хорооны хөдөлмөрийн асуудал хариуцсан ажилтнуудыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангахад удирдамжийн зорилго оршино.

1.2. Удирдлага, зохион байгуулалт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

1.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам мэргэжлийн удирдлагаар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар зохицуулалт, арга зүйгээр хангаж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс зохион байгуулж, дэмжлэг үзүүлж ажиллана.

1.2.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл болон сум, дүүрэг, хорооны Засаг дарга, иргэдийн төлөөллийн байгууллага байнгын хяналт тавина.

1.2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн холбоод, сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж, хамтран ажиллана.

1.2.4. Хөтөлбөрийг хянаж, үнэлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүрээнд баримтлах хяналт, үнэлгээ, тайлагналтын журмыг мөрдөнө. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн хяналт-үнэлгээг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар жилд 2-оос доошгүй удаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

1.2.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийн сарын тайлан, мэдээг дараа сарын 3-ны дотор, улирлын тайлан, мэдээг дараа улирлын эхний сарын 3-ны дотор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт, тус газар нь тайлан, мэдээг ажлын 3 хоногт багтаан нэгтгэн дүгнэж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлнэ.

1.2.6. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх болон хамрагдаж буй иргэдийн мэдээллийг Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд тогтмол бүртгэж, шинэчилнэ.

1.2.7. Хөтөлбөрийн үр дүнг хянаж, үнэлэхдээ захиргааны журмаар тогтмол давтамжтай цуглуулах тоо мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилтийг газар дээр нь танилцаж цуглуулсан чанарын мэдээлэл, хөндлөнгийн мөшгих судалгаа, үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ[1] зэрэг арга хэрэгслийг зохистой хэлбэрээр ашиглана.

---

[1] Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх цогц сургалтын болон бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний үр нөлөөллийг хэмжихийн тулд эдгээр арга хэмжээнд хамрагдах хүсэлт гаргасан боловч хамрагдаагүй иргэдийн дундаас хяналтын бүлэг байгуулна.

1.2.8. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь хөтөлбөрийн арга хэмжээ тус бүрт хамаарах бүртгэл, мониторинг, тайлан, холбогдох судалгааны маягтуудыг боловсруулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудаас тэдгээрийг цахим хэлбэрээр хүлээж авах техникийн боломж бүрдүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

1.2.9. Хөтөлбөрийн санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан, бичиг баримт хуурамчаар үйлдсэн болон бусад зөрчил, дутагдал гаргасан нь холбогдох байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтаар тогтоогдвол олгосон санхүүжилтийг буцаан төлүүлэх арга хэмжээ авч, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

1.2.10. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагууд авлигаас ангид ажиллах бөгөөд "Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын Хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдэд залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох тухай удирдамж[2] нь туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх байгууллагатай хийх гэрээний нэг хавсралт болж мөрдөгдөнө.

1.3. Нийгэм, байгаль орчны удирдлагын хүрээ

1.3.1. Нийгэм ба хамгааллын асуудал

1.3.1.1. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд иргэдийн санал хүсэлтийг авах, санал солилцох, ил тод байдлыг хангах механизмыг бэхжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд, 1) хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт, бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ болон орон нутгийн санаачилгын төслийн үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийн үзүүлэлтийг ашиглаж, үр дүнг хянах, 2) туршилтын хөтөлбөрийн зорилго, зорилтын хэрэгжилтийн талаар хөтөлбөрт оролцогч талуудтай тогтмол санал солилцох, 3) хөтөлбөрт оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, 4) орон нутагт шинээр санаачлан хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн туршилтын төслийг боловсруулахдаа зорилтот бүлгийн иргэдтэй зөвлөлдөх.

1.3.1.2. Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрөөс үндэсний цөөнх казах иргэд үр шим хүртэх байдлыг нэмэгдүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны талаарх шаардлагатай мэдээллийг эх хэл дээр нь бэлтгэн түгээнэ.

1.3.1.3. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн зах зээл дээрх хүйсийн тэгш байдлыг хангах асуудалд анхаарах бөгөөд хөтөлбөрт туссан гол арга хэмжээнүүд нь хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна. Түүнчлэн, хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар мэдээллийг эмэгтэйчүүдэд илүү хүртээмжтэй байдлаар хүргэх, бичил бизнес эрхлэгчид эмэгтэйчүүдийн хувьд үр дүнтэй байдаг нь батлагдсан санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээг хослуулан үзүүлэх, орон нутгийн санаачилгын төслийн саналыг шалгаруулахдаа хөдөлмөрийн зах зээл дэх хүйсийн тэгш байдлыг хангахыг тухайлан зорьсон төслийг илүү дэмжихэд анхаарна. Төсөл хэрэгжүүлэх бүх хугацаанд үр шим хүртэгч эмэгтэй, эрэгтэйчүүдийн тоог холбогдох үзүүлэлтүүдийн дагуу хянана.

1.3.1.4. Шилжин суурьшигчид, эмзэг бүлгийн залуучууд, ерх толгойлсон эмэгтэйчүүд/эрэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн хөтөлбөрт хамрагдахгүй байх эрсдэлийг бууруулах үүднээс зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн мэдээлэл түгээх арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн сургалтад хамрагдах хугацаанд суралцагчдад хоол, унааны зардлын хөнгөлөлт олгох, залуучууд болон нийгмийн хамгийн эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн орон нутгийн санаачилгын төслүүдийг дэмжиж хэрэгжүүлнэ.

---

[2] Энэхүү тушаалын Арванхоёрдугаар хавсралтаар батлав.

1.3.2. Байгаль орчин, аюулгүй байдал

1.3.2.1. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд байгаль орчны томоохон эрсдэлтэй үйл ажиллагаа, бичил бизнесийг дэмжихгүй бөгөөд үр шим хүртэгчийн үйл ажиллагаа нь байгаль орчинд ихээхэн хэмжээний, нөхөн сэргээх боломжгүй хохирол учруулахааргүй байна. Салбарын онцлогоос хамаарч зарим төрлийн үйл ажиллагаа, тухайлбал, худалдаа арилжаа, үйлчилгээ болон жижиг үйлдвэрлэл нь дуу чимээ, хог хаягдал гаргах тохиолдолд тэнд ажиллагчид, гэр бүлийн гишүүд болон олон нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.3.2.2. Бичил бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болох орчны нөлөөг үнэлэх, шаардлага хангахгүй бизнесийн өргөдлийн хүсэлтийг дэмжихгүй байх, шаардлагатай үед сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ[3] авч хэрэгжүүлнэ.

1.3.2.3. Хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг авсан бичил бизнесийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал (БОЭМАБ)-ыг хангах ерөнхий шаардлагыг хангахад Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банк, жижиг зээл авсан иргэн, зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хариуцан гүйцэтгэх байгууллага зэрэг оролцогч бүх талууд үүрэг хүлээнэ. Бичил бизнесийн зарим төрлүүдэд тухайн салбарын онцлогт нийцсэн БОЭМАБ-ны нэмэлт шаардлагуудыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулан хэрэгжүүлнэ.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг хэрэгжүүлэх удирдамж

2.1. Мэргэжлийн сургалтын чиглэлийг тодорхойлох

2.1.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийн асуудал эрхэлсэн газар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг харгалзан Нийслэлийн төвийн 6 дүүрэгт зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чиглэлийг тодорхойлно. Тухайлбал, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг дараах судалгааны үр дүн, бодлогын тэргүүлэх чиглэлийг үндэслэж тодорхойлно. Үүнд:

2.1.1.1 “Хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлтийн судалгаа”-ны өмнөх 3 жилийн үр дүн[4],

2.1.1.2. “Дунд, урт хугацааны хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн таамаглал”[5],

2.1.1.3. “Ур чадварын эрэлтийн судалгаа”[6].

2.1.1.4. Аймаг, нийслэлийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, салбарууд.

2.1.2. Түүнчлэн, хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын (цаашид цогц сургалт гэх) чиглэлийг тодорхойлохдоо дараах нөхцөл байдлыг харгалзаж үзнэ. Үүнд:

2.1.2.1. Чадамжийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тодорхойлогдсон буюу тодорхойлох боломжтой, мөн чадамжийн хөндлөнгийн үнэлгээний чадавх бүрдсэн болон бүрдэх боломжтой мэргэжлийн чиглэлүүдэд ач холбогдол өгнө.

2.1.2.2. Цогц сургалтын чиглэл, үргэлжлэх хугацааг тогтоохдоо холбогдох мэргэжлийн холбоодтой зөвлөлдөнө.

2.1.2.3. Хүйсийн ялгавартай хандлагаас улбаатай хэвшмэл ойлголт, зан үйлийн нөлөөгөөр аль нэг хүйсийн иргэд мэргэжлийн тухайлсан чиглэлийг зонхилж

---

[3] Дэлгэрэнгүй мэдээллийг Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн “Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээ” баримт бичгээс харна уу.

[4] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс хэрэгжүүлдэг судалгаа.

[5] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс хэрэгжүүлдэг судалгаа.

[6] Дэлхийн банкны санхүүжилттэй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн 3-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хийгдэнэ.

сонгох магадлалтайг тооцож, мэргэжлийн сургалтуудад аль нэг хүйсийн иргэд давамгай хамрагдах нөхцөл бүрдэхээс сэргийлнэ.

2.1.2. Аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, тухайн орон нутгийнхаа мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага, сул ажлын байртай байгаа тодорхой ажил олгогчтой хамтран ажлын байрны бодит эрэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын чадавхад тулгуурлан тухайн орон нутагт зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чиглэлийг тодорхойлж, сургалт зохион байгуулах ерөнхий санал[7] боловсруулна.

2.1.3. Аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүргээс ирүүлсэн саналыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар ХЗЗДТХ-д тусгагдсан шаардлагын дагуу хянаж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтындэлгэрэнгүй төсөл[8] боловсруулж ирүүлэхийг мэдэгдэнэ. Төсөл нь хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын бүрэлдэхүүн хэсгийг бүгдийг нь орхигдуулалгүй хамарсан байна.

2.2. Сургалтын байгууллага, сургалтын төсөл шалгаруулах

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт:

2.2.1. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ХНХЯ-наас тодорхойлсон сургалтын чиглэлээр тухайн жилд уг орон нутагт хэдэн хүн сургах хэрэгцээтэй байгааг харгалзан сургалтын суудлын тоог мэргэжлийн чиглэл бүрээр тогтоох ба энэ нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулахад баримтлах суудлын тооны үндэслэл болно.

2.2.2. Сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах зарыг сонгон шалгаруулалт товлогдсон хугацаанаас 30 хоногоос багагүй хугацааны өмнө зарлана. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах ажлын хэсэгт ажил олгогчдын эсвэл төрийн бус байгууллагын заавал оролцуулна. Түүнчлэн, сонгон шалгаруулалтаар шигшигдсэн сургалтын байгууллагууд цогц сургалтыг зохион байгуулах орчин, шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг нягталж тогтоохдоо тухайн мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллана. Мэргэжлийн холбоодын төлөөлөгчид ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

2.2.3. Сонгон шалгаруулалтад оролцогч сургалтын байгууллагууд дор дурдсан нөхцөл, шаардлагыг хангаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлсэн байна. Үүнд:

2.2.3.1. Мэргэжлийн үндсэн багштай, мэргэжлийн багш нь насанд хүрэгчдэд заах арга зүй, ур чадвартай байх[9],

2.2.3.2. Сургалтын орчны стандарт нөхцөлийг хангасан онол, дадлагын байр, танхим, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байх,

2.2.3.3. Цогц сургалтын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулсан, сургалтын бүрэлдэхүүн хэсэг бүрийн хэрэгжих хугацаа (хоног) тодорхой байх,

2.2.3.4 Чадамжид суурилсан мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг ажил олгогчийн эрэлтэд нийцүүлэн[10] боловсруулсан, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр ба суралцагчийн ахиц дэвшлийн үнэлгээний төлөвлөгөөг Мэргэжлийн боловсрол, сургалтын бүсийн арга зүйн төвөөр дүгнэлт гаргуулж, баталгаажуулсан байх,

---

[7] Ерөнхий саналын загварыг ХХҮЕГ батална.

[8] Дэлгэрэнгүй төслийн загварыг ХХҮЕГ батална.

[9] Насанд хүрэгчдэд заах арга зүйн сургалтад хамрагдсаныг нотлох бичиг баримтыг хавсаргана. Хэрэв үндсэн багш нь тухайн мэргэжлийн нэгдсэн холбоо, эсвэл Мэргэжлийн зөвлөлөөр ур чадвар нь баталгаажсан бол энэ нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулахад давуу тал болно.

[10] Ажил олгогчдын зүгээс боловсруулсан ажил мэргэжлийн лавлахыг сургалтын хөтөлбөр боловсруулахдаа бүрэн ашиглаж, тусгасан байна:

2.2.3.5. Модульт сургалтуудын хөтөлбөрийг боловсруулж баталгаажуулсан, эрх бүхий бусад сургалтын байгууллагуудтай хамтран зохион байгуулах бол тухайн сургалтын байгууллагын нэр, хаяг, сургалт явуулах эрх, сургагч багшийн туршлага зэрэг мэдээллийг багтаасан байх,

2.2.3.6. Тухайн мэргэжлийн чиглэлээр өмнөх 2 жилийн хугацаанд сургалт зохион байгуулсан, сургалтын үр дүнг тодорхой тоо баримтаар нотолсон байх,

2.2.3.7. Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулах хөтөлбөрийг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулсан, хамтран ажиллах тухай урьдчилсан байдлаар зөвшилцсөн аж ахуйн нэгжийн жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт хавсаргасан байх,

2.2.3.8. Сургалт дууссанаас хойш 3 сарын хугацаанд төгсөгчдөд үзүүлэх дэмжлэгийн төрөл, төлөвлөгөөг боловсруулсан байх.

2.2.4. Сонгон шалгаруулалтанд оролцохоор саналаа ирүүлсэн байгууллагуудыг хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулахад тавигдах дээрх нөхцөл, шаардлагыг хангасан эсэхээр нь шигшиж, улмаар дараах шалгуур үзүүлэлтийг ашиглан сонгон шалгаруулж, үр дүнд суурилсан санхүүжилтийн гэрээ[11] байгуулна. Үүнд:

2.2.4.1. Сургалтын амлаж буй, зорилтот үр дүн буюу тухайн мэргэжлийн мэргэшлийн II түвшний чадамжийн бүх нэгжийг эзэмшсэн нь хөндлөнгийн үнэлгээгээр баталгаажиж, гэрчилгээ авсан төгсөгчийн нийт суралцагчид эзлэх хувь[12],

2.2.4.2. Сургалтын үнийн санал,

2.2.4.3. Сургалтын суудлын тоо.

2.2.5. Сургалтын байгууллага нь сургалтын үнийн саналаа боловсруулахдаа дараах асуудлыг анхаарна. Үүнд:

2.2.5.1. Үнийн саналыг мэргэжлийн сургалтын нэг долоо хоног буюу ажлын 5 хоногт нэг суралцагчид ногдох зардалд үндэслэж тооцох ба батлагдсан дээд хэмжээнээс[13] хэтрээгүй байна.

2.2.5.2. Цогц сургалтын бүрэлдэхүүнд багтсан бусад модульт сургалтын зардлыг тооцохдоо батлагдсан жишгийг[14] мөрдөнө.

2.2.5.3. Төгсөгчдөд сургалтын дараах 3 сарын хугацаанд дэмжлэг үзүүлэх нь цогц сургалтын салшгүй хэсэг тул энэ үйл ажиллагаанд зориулсан санхүүжилтийг сургалтын байгууллагад олгохгүй.

2.2.5.4. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын байгууллагыг сонгон шалгаруулсан шийдвэр, үндэслэлийг шалгаруулалт явагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор өөрийн цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад арга хэрэгслээр дамжуулан оролцогч сургалтын байгууллагууд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

Аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт:

2.2 .6. Аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг тухайн орон нутагт байрлаж үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага орон нутгийн ажлын байрны бодит хэрэгцээнд үндэслэсэн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын захиалгын дагуу зохион байгуулна.

2.2.7. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бүр хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажил олгогчтой хамтран боловсруулсан хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах ерөнхий

---

[11] Энэхүү тушаалын Хоёрдугаар хавсралтаар гэрээний загварыг батлав.

[12] Сургалтын байгууллагын амлах үр дүнгийн босго 70.0 хувиас доошгүй байна.

[13] Энэхүү тушаалын Тавдугаар хавсралтаар мэргэжлийн сургалтын зардлын жишиг хэмжээг батлав.

[14] Энэхүү тушаалын Зургаадугаар хавсралтаар модульт сургалтын зардлын жишиг хэмжээг батлав.

саналаа сургах мэргэжлийн чиглэл тус бүрээр боловсруулж[15], орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар дамжуулан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ. Ерөнхий саналд дараах мэдээллийг заавал оруулсан байна. Үүнд:

2.2.7.1. Сургах мэргэжлийн чиглэл, индекс[16], мэргэшлийн түвшин[17], эзэмшүүлэх чадамжийн нэгжийн жагсаалт,

2.2.7.2. Тухайн мэргэжлийн сургалтаар сургах хүний тоо[18],

2.2.7.3. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын агуулгын дагуу мэргэжлийн сургалт, ажлын байран дээрх дадлагын үргэлжлэх хугацаа,[19]

2.2.7.4. Модульт сургалт, ажил хайх ур чадварыг дээшлүүлэх сургалты зохион байгуулах арга зам

2.2.7.5. Ажлын байран дээрх дадлагыг өөрийн аж ахуйн нэгж дээр хийлгэж, амжилттай төгсөгчдийг ажлын байраар хангах тухайг илэрхийлсэн ажил олгогчийн албан бичиг[20],

2.2.7.6. Сургалтын дараах 3 сарын дэмжлэгийг зохион байгуулах арга зам,

2.2.7.7. Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар,

2.2.7.8. Ажлын байраар хангах аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар,

2.2.8. Аймаг, алслагдсан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас ирүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтынсаналыг ХХҮЕГ хянаж, шаардлага хангасан гэж үзвэл тухайн мэргэжлийн чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах дэлгэрэнгүй төсөл боловсруулж ирүүлэхийг мэдэгдэнэ.

2.2.9. Үүний дагуу орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, ажил олгогчтой хамтран хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах дэлгэрэнгүй төсөл боловсруулна. Төсөлд энэхүү удирдамжийн 2.2.3 дахь шаардлагууд, 2.2.4.1-ээс 2.2.4.3 болон 2.2.5.1-ээс 2.2.5.3 дахь нөхцөлүүдийг тусгана. Төслийг зөвшөөрөл авснаас хойш 1 сарын хугацаанд багтаан бэлтгэж, ХХҮЕГ-т ирүүлнэ.

2.2.10. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ирүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах хамтарсан төслийг хянаж, даргын тушаалаар баталгаажуулна.

2.2.11. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын шийдвэрт үндэслэн сургалтын байгууллагатай үр дүнд суурилсан санхүүжилтийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.3. Сургалтад хамрагдах иргэдийг сонгох

2.3.1 Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь цогц сургалт, түүнд хамрагдах нөхцөлийн талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад арга хэрэгслийг ашиглан орон нутгийн хүн ам, зорилтот бүлгийн иргэдэд өргөн хүрээнд, энгийн, ойлгомжтойгоор сурталчилан түгээж, сонирхсон иргэдийг урьдчилан бүртгэнэ. . Шаардлагатай мэдээллийг казах иргэдэд зориулан төрөлх хэл дээр нь бэлтгэж, түгээнэ.

2.3.2. Нийслэлд сургалтын байгууллагыг сонгон шалгаруулсны дараа, аймаг, алслагдсан 3 гурван дүүрэгт сургалт зохион байгуулах шийдвэр гарсны дараа

---

[15] Сургалт явуулах мэргэжлийн чиглэл нэг бүрээр тус тусад нь ерөнхий санал боловсруулна.

[16] Тухайн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн чиглэлийн дагуу сургах мэргэжлийн чиглэлээ тогтооно. Мэргэжлийн чиглэлийн нэр, индексийг БСШУ-ны сайдын 2016 оны А/150 дугаар тушаалын дагуу тодорхойлно.

[17] Мэргэжлийн чиглэл, ажил олгогчийн хэрэгцээнээс хамаарч III түвшний чадамжийн нэгж оруулж болно.

[18] Нэг анги дүүргэлт хамгийн багадаа 15 хүнтэй байна.

[19] Мэргэжлийн сургалтын танхимын сургалт 7-9 долоо хоног, ажлын байран дээрх дадлага 7-8 долоо хоног байна.

[20] Хэд хэдэн ажил олгогч байж болно.

сургалтад хамрагдах иргэдийг урьдчилан бүртгүүлсэн иргэдийн дундаас сонгоно. Сургалтад хамрагдах иргэний насны доод хязгаар 18 байна.

2.3.3. Цогц сургалтад хамрагдах иргэдийг сонгохдоо тухайн орон нутгийн оршин суугч иргэдийг эхлэн сургах чиглэл баримтална.

2.3.4. Иргэн сургалтад хамрагдах хүсэлтээ харьяа/оршин суугаа аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бичгээр гаргаж, суралцахыг хүссэн чиглэл болон үндэслэлээ тодорхой дурдана. Аймаг, алслагдсан 3 дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сонирхсон иргэдийг ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээнд хамруулж, сургалт хамтран зохион байгуулах ажил олгогч болон ажлын байртай урьдчилан танилцуулан, сургалтын дараа тухайн ажлын байранд шууд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Нийслэлийн төвийн 6 дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь шаардлагатай бол сонирхсон иргэдийг ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээнд хамруулж, суралцах мэргэжлийн чиглэлээ сонгоход нь дэмжлэг үзүүлнэ.

2.3.5. Сургалтад хамрагдах иргэнийг дараах шинж байдлаар нь оноогоор үнэлж, сонгоно. Үүнд:

2.3.5.1. Тухайн орон нутагт оршин суугч бүртгэлтэй иргэн:	16 оноо
2.3.5.2. 18-34 насны иргэн:	8 оноо
2.3.5.3. Ажил олоход хүндрэлтэй иргэн[21]:	4 оноо
2.3.5.3. Бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой:	2 оноо
2.3.5.4. Сургалтад хамрагдах хүсэл нь ажил эрхлэх зорилготой нь уялдсан:	1 оноо

2.3.6. Ажил хайгч иргэний бүртгэл болон иргэний бичгээр гаргасан хүсэлт[22] нь дээрх үзүүлэлтийн дагуу оноо өгөхөд хэрэгцээтэй мэдээллийн эх сурвалж болно. Хамгийн өндөр оноотой иргэдийг сургалтад хамруулна[23].

2.3.7. Онооны үнэлгээгээр ижил оноо авсан иргэдийг Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийн мэдээлэлд үндэслэн ажил идэвхтэй хайсан байдлыг нь харгалзан эрэмбэлнэ.

2.3.8. Сургалтад хамрагдагчдын 50-иас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна. Бичиг үсэгт тайлагдаагүй иргэнийг сургалтад хамруулахгүй. Мөн өмнө нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад удаа дараа хамрагдаж байсан иргэн хүсэлт гаргаж, оноогоор тэнцсэн байлаа ч суралцах, ажил эрхлэх зорилго нь сайн уялдаагүй, ажил эрхлэх хүсэл нь тууштай бус байвал заавал уг иргэнийг сургах чиглэл баримтлахгүй.

2.3.9. Хэрэв мэргэжлийн нэг чиглэлээр хоёр ба түүнээс дээш сургалтын байгууллагыг сонгон шалгаруулсан бол иргэнд сургалтын байгууллагуудаас сонголт хийх боломж олгоно.

2.3.10. Аймаг, нийслэл, алслагдсан 3 дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтад хамрагдахаар сонгогдсон иргэдийн оноогоор эрэмбэлэгдсэн нэрсийн жагсаалтыг мэргэжлийн чиглэл бүрээр өөрсдийн цахим хуудсаар болон нийтэд зориулсан мэдээллийн самбарт тавьж, ил тод мэдээлнэ.

2.3.11. Сургалтын байгууллага нь суралцагч нэг бүртэй гэрээ[24] байгуулж, сургалтын зорилго, бүрэлдэхүүн, хугацаа, хүлээгдэх үр дүн зэргийг танилцуулж, сургалтын үр дүнг хангахын төлөө суралцагчийн хүчин чармайлтыг дэмжин, идэвхжүүлж ажиллана.

---

[21] Сургалтын байрны тохируулга, тусгай тоноглол шаардахгүйгээр суралцах боломжтой хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг багтаана.

[22] Иргэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас баталсан маягтын дагуу хүсэлт гаргана.

[23] Хөтөлбөрийн үр нөлөөллийн үнэлгээний зорилгын хүрээнд шаардлагатай бол босго оноог өөрөөр тогтоож болно.

[24] Энэхүү тушаалын Гуравдугаар хавсралтаар гэрээний загварыг батлав.

2.3.12. Аймаг, нийслэл, алслагдсан 3 дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтад хамрагдахаар сонгогдсон иргэн бүрийг сургалтын өмнөх ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох дараах чиглэлийн зөвлөгөө, үйлчилгээнд заавал хамруулж, зөвлөгөөний үр дүнг баримтжуулж, улмаар сургалтын дараа иргэний ажил эрхлэлтийн нөхцөлд гарч буй ахиц, дэвшлийг үнэлж, шаардлагатай дэмжлэг, зөвлөгөө өгч ажиллана. Үүнд:

2.3.12.1. Тухайн иргэний ажилгүйдлийн шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, нөхцөл байдалд үнэлгээ хийх,

2.3.12.2. Иргэний ажил эрхлэлтийн зорилго, төлөвлөгөөг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх,

2.3.12.3. Ажилтай, орлоготой болох эрмэлзлийг нь нэмэгдүүлэх,

2.3.12.4. Сургалтын байгууллагыг сонгоход нь зөвлөгөө өгөх,

2.3.12.5. Аймаг, алслагдсан 3 дүүрэгт ажил олгогчидтой урьдчилсан уулзалт зохион байгуулах, ажлын байртай танилцуулах, сургалтын дараа тухайн ажлын байранд ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх.

2.4. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх

2.4.1. Хандлага, төлөвшил, харилцааны чадварын сургалт нь бие дааж ажиллах, багаар ажиллах, бүтээлч, санаачилгатай байх, хариуцлага хүлээх, асуудлыг илрүүлэх, шийдвэрлэх, ажлын болон харилцааны ёс зүй, зөв хандлагатай байх зэрэг хөдөлмөр эрхлэхэд шаардагдах чадварыг эзэмшүүлэхэд чиглэнэ. Сургалтын үргэлжлэх хугацаа 5 өдөр, нийт 32-оос доошгүй цагийн хугацаатай байна. Энэхүү сургалтыг чадамжид суурилсан сургалтын модулиуд[25], оролцооны арга ашиглаж, мэргэжлийн сургалт эхлэхээс өмнө зохион байгуулна. Энэ сургалтаас гадна хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт бүхэлдээ суралцагчийн хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дээшлүүлэхэд онцгойлон анхаарна.

2.4.2. Мэргэжлийн сургалт болон ажлын байран дээр дадлагажуулах хөтөлбөрийг хослуулан тухайн мэргэжлийн мэргэшлийн II түвшний чадамжийн бүх нэгжийг эзэмшүүлнэ. Мэргэжлийн сургалт нь чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн дагуу 7-9 долоо хоног үргэлжилнэ. Мэргэжлийн сургалтын танхимын сургалтын онол, дадлагын бүрэлдэхүүний харьцаа 30/70, 5 өдрийн сургалт нь 36-аас доошгүй цагийн хөтөлбөртэй байна. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт суралцагчийн ахиц, дэвшлийн үнэлгээний төлөвлөгөөг тусгах ба уг үнэлгээг гүйцэтгэлийн тодорхой шалгуур үзүүлэлтүүд ашиглаж хийнэ.

2.4.3. Компьютер, цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалтыг шаардлагатай бол эрх бүхий сургалтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулна. Сургалтын хугацаа 5 өдөр, нийт 32-оос доошгүй цаг байх ба чадамжид суурилсан сургалтын модуль ашиглана. Сургалтын өөр байгууллагатай хамтран зохион байгуулах бол гэрээ байгуулж, гэрээнд сургалтаас хүлээж буй үр дүнг тусгаж, дүгнэж ажиллана. Сургалтаар олгохыг зорьсон чадамжийг суралцагч бүр хэрхэн гүйцэтгэснийг сорьж сургалтын үр дүнг тооцно.

2.4.4. Хувь хүний санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг холбогдох хөтөлбөрийн дагуу[26], 3 өдөр, нийт 18-аас багагүй цагийн хугацаатайгаар, ажлын байран дээрх дадлага дуусмагц зохион байгуулна. Шаардлагатай бол энэ сургалтыг эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах бөгөөд энэ тохиолдолд гэрээ байгуулж, гэрээнд сургалтаас хүлээж буй үр дүнг тусгаж,

---

[25] Хөдөлмөрийн яамнаас 2013 онд боловсруулсан "*Харилцааны ур чадвар эзэмших*" – Чадамжид суурилсан сургалтын 54 цагийн модуль, мөн НҮБ-ын Хүн амын сан, АНУ-ын Энх тайвны корпус, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр боловсруулсан "*Амьдрах ухааны сургалтын модулиуд*"-ыг ашиглан чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулах боломжтой.

[26] ХНХЯ, Монгол банк хамтран боловсруулж буй хөтөлбөр.

дүгнэж ажиллана. Сургалтаар олгохыг зорьсон чадамжийг суралцагч бүр хэрхэн гүйцэтгэснийг сорьж сургалтын үр дүнг тооцно.

2.4.5. Удирдамжийн 2.4.1-д заасан сургалтын жишиг хөтөлбөр боловсруулах, сургалт явуулах байгууллагуудын сургагч багшийг бэлтгэх ажлыг нэгдсэн байдлаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зохион байгуулна. 2.4.3-т заасан сургалтын хөтөлбөрийг сургалтын байгууллага ижил төстэй сургалтын хөтөлбөрт тулгуурлан, 2.4.4.-т заасан сургалтын хөтөлбөрийг 2017 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Монгол банктай хамтран боловсруулсан "Хувь хүний санхүү, бизнес аж ахуй эрхлэлт" хичээлийн сургалтын хөтөлбөрт тулгуурлан сургалтын байгууллага боловсруулан бүсийн аргазүйн төвөөр дүгнэлт гаргуулсан байна.

2.4.6. Ажлын байран дээрх дадлагын хугацаа 7-8 долоо хоног байна. Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажиллах аж ахуйн нэгжийг дараах шалгуурын дагуу сонгоно. Үүнд:

2.4.6.1. Тухайн мэргэжлийн чадамж, ур чадвар шаардсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг,

2.4.6.2. Өмнөх 12 сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 3-аас доошгүй тооны ажилтантай,

2.4.6.3. Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан,

2.4.6.4.Тухайн мэргэжлийн чадамж, ур чадварыг зааж, дадлагажуулах боломжтой, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай ажилтантай,

2.4.6.5. Сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол үйл ажиллагаа эрхэлсэн,

2.4.6.6. Үйлдвэрлэл, үйлчилгээний байрны хаяг тодорхой.

2.4.6.7. Тухайн мэргэжлийн чиглэлд дадлагын багшаар тусгайлан сургагдсан[27] ажилтантай бол давуу тал болно.

2.4.6.8. Аймаг, алслагдсан 3 дүүргийн ажил олгогч нь тухайн суралцагчийг ажилд авах бодит ажлын байртай, сургалтын дараа шууд ажлын байраар хангах боломжтой байна.

2.4.7. Суралцагчийг аль болохоор олон ажилтантай аж ахуйн нэгжид дадлагажуулах чиглэл баримтална. Тухайн аж ахуйн нэгжийн 2.4.6.2.-д заасан ажилчдын тоо ба дадлагажих суралцагчийн тооны харьцаа 2:1 -ээс багагүй байна.[28]

2.4.8. Сургалтын байгууллага нь сонгон шалгаруултанд оролцохдоо бүрдүүлсэн урьдчилсан жагсаалт, эсвэл нэмж өөрчилсөн жагсаалтад багтсан аж ахуйн нэгжүүд дээрх шаардлагыг хангаж буй эсэхийг нотлох мэдээллийг харьяа аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дадлагажуулалт эхлэхээс дөрвөн долоо хоногоос доошгүй хугацааны өмнө хүргүүлнэ. Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь санал болгосон аж ахуйн нэгжүүд тавьсан шаардлагыг хангаж буй эсэхийг хянаж тогтоосны үндсэн дээр тухайн аж ахуйн нэгжүүдтэй гурван талт гэрээ байгуулахыг сургалтын байгууллагад зөвшөөрнө.

2.4.9. Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтарч ажиллах талаар сургалтын байгууллага, сонгогдсон аж ахуйн нэгж болон аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гурван талт гэрээ байгуулна[29]. Гэрээнд талуудын хүлээх үүрэг, суралцагчийн ажил, амралтын цагийн хязгаарыг тогтоох, ирцийг хянах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг

---

[27] ХНХЯ/ХХҮЕГ-аас дадлагын багшаар сургасан.

[28] Жишээ нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 4 ажилтантай аж ахуйн нэгжид дадлагажих хүний тоо 2-оос ихгүй, 10 ажилтантай аж ахуйн нэгжид дадлагажих суралцагчийн тоо 5-аас ихгүй байна.

[29] Энэхүү тушаалын Дөрөвдүгээр хавсралтаар аж ахуйн нэгж, сургалтын байгууллага, аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хооронд байгуулах гурван талт гэрээний загварыг батлав.

хамгаалах, мөн суралцагчийн чадамжийг дээшлүүлэх асуудлыг тусгана. Энэ гэрээнд тухайн аж ахуйн нэгж дээр дадлагажих суралцагчдын нэрсийн жагсаалтыг хавсаргах ба уг жагсаалтад суралцагч бүрийн тухайд сайжруулбал зохих чадамжийн нэр, чадамжийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, гүйцэтгэлийн тухайн үеийн болон дадлагажилтийн төгсгөлөөр зорьж буй түвшин зэргийг сургалтын байгууллага ба аж ахуйн нэгж хамтран тодорхойлж, тусгасан байна. Энэ нь дадлагажуулалтын үр дүнг тооцох гол хэрэгсэл болно.

2.4.10. Ажлын байран дээрх дадлагаар тухайн мэргэжлийн мэргэшлийн II түвшний чадамжийн нэгжийн 50-иас доошгүй хувийг сайжруулахыг зорино. Дадлагажуулалтын үр дүнг сургалтын байгууллага ба аж ахуйн нэгж хамтран дүгнэхэд аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын төлөөлөл хөндлөнгийн хяналт тавина. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь нийслэл дэх сургалтын байгууллагатай хамтарч ажилласан аж ахуйн нэгжийн тоог харгалзан шаардлагатай бол Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй хамтран нийслэлийн төвийн зургаан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын холбогдох ажилтнуудыг сургалтад хамруулж, ажлын байран дээрх дадлагажуулалтын үр дүнг үнэлэх үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавихад татан оролцуулж болно.

2.4.11. Суралцагчийг илүү цагаар болон шөнийн цагаар ажиллуулахгүй.

2.4.12. Сургалтын байгууллага нь гурван талт гэрээний үр дүнг хангахын төлөө аж ахуйн нэгжид арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. Сургалтын байгууллагын багш хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллага дээр тодорхой хугацаанд дагуу очиж, мэргэжлийн зааварчилгаа өгөх, мэдлэг, туршлагаа хуваалцах зэргээр дэмжлэг үзүүлнэ. Түүнчлэн, аж ахуйн нэгж гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавина.

2.4.13. Аж ахуйн нэгжид олгох урамшууллыг дадлагын үр дүнг үндэслэж олгоно. Суралцагч бүрийн тухайд сайжруулбал зохих чадамжийн зорилтын биелэлт нийт суралцагчдын дунджаар 70 хувиас доошгүй түвшинд биелсэн бол аж ахуйн нэгжид олгох урамшууллыг бүтэн олгоно. Харин үр дүнгийн биелэлт 60-69 хувьтай бол урамшууллыг 10 хувиар, 50-59 хувьтай бол урамшууллыг 20 хувиар, 40-49 хувьтай бол урамшууллыг 30 хувиар гэх зэргээр хасч олгоно.

2.4.14. Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэргэжлийн сургалт, модульт сургалт, ажлын байран дээрх дадлагыг нийт 2 долоо хоногоос дээш хугацаагаар тасалсан бол сургалтаас хасна. Сургалтаас завсардаж, хасагдсан суралцагчдын нэр, хасагдсан шалтгаан, өдрийг тодорхой дурдсан мэдээллийг сар бүрийн сүүлчийн өдрөөр тасалбар болгож харьяа аймаг, нийслэл, алслагдсан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бичгээр хүргүүлнэ.

2.4.15. Цогц сургалтад хамрагдсан иргэдийн хөдөлмөрийн зах зээлд шилжих шилжилтийг хөнгөвчлөх зорилгоор аймаг, нийслэл, алслагдсан дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын байгууллагын хүсэлтийн дагуу ажил хайх чадварыг дээшлүүлэх 2 өдрийн бүлгийн сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас баталсан жишиг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, сургалтын зардлыг хариуцна. Сургалтын байгууллага нь ийм сургалт авах хүсэлтээ сургалт явуулахаар төлөвлөсөн хугацаанаас дөрвөөс доошгүй долоо хоногийн өмнө харьяа аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

2.4.16. Сургалтын байгууллага нь сургалтын дараах 3 сарын хугацаанд төгсөгч бүртэй холбоо харилцаатай байж, төгсөгч ажил хайх, шаардлагатай бол харьяа аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэх, бүртгэлээ идэвхижүүлэх, эсвэл хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, мэргэжил, ур чадвартай нь холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туслах, мэдээллээр хангах зэрэг дэмжлэг үзүүлнэ.

2.4.17. Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь иргэнд ажил эрхлэлтийн зөвлөгөө өгөх, ажилд зуучлах зэрэг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үр дүнтэй үзүүлнэ.

2.5. Чадамжийн хөндлөнгийн үнэлгээ, үнэлгээний төлбөр

2.5.1. Төгсөлтийн дараах хөндлөнгийн үнэлгээг холбогдох журмын дагуу[30] сургалтын байгууллагаас ирүүлсэн хүсэлт, захиалгад үндэслэн жил бүр нийслэл, орон нутагт зохион байгуулна.

2.5.2. Сургалтын байгууллага нь төгсөгчдийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд урьдчилж төлнө. Хөндлөнгийн үнэлгээний төлбөрийн ХЭДС/ХЗЗДТХ-с хариуцах хэсгийг хөндлөнгийн үнэлгээний болон үнэлгээний материалын зардалд үндэслэн батлагдсан төлбөрийн хэмжээнд багтаан сургалтын байгууллагад нөхөж олгоно.

2.5.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь чадамжийн үнэлгээний дүнг сургалтын байгууллага тус бүрээр батлагдсан маягтын дагуу цахим мэдээллийн санд бүртгэн байршуулж, үнэлгээний дэлгэрэнгүй дүн мэдээг үнэлгээ явагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор бичгээр хоёр хувь үйлдэж, сургалтын байгууллагад үнэ төлбөргүй өгнө. Энэ нь сургалтын байгууллагын үр дүнг тооцох нотолгоо болно.

2.5.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь чиг үүргийнхээ дагуу бүрдүүлсэн мэдээллийн санд тулгуурлан мэргэжлийн сургалтын байгууллагуудын сургалтын чанар, үр дүнг илтгэх мэдээллийг батлагдсан маягтын дагуу өөрийн цахим хуудастаа байршуулж, тухай бүр шинэчлэн, ил тод мэдээлнэ. Энэ нь сургалтын байгууллагуудын өрсөлдөөнийг дэмжих, сургалтын байгууллагын үр дүнг ил тод болгох, ажил хайгч иргэд сургалтын байгууллагаа сонгоход дэмжлэг үзүүлэх зорилготой. МБСҮТ-ийн чадамжийн үнэлгээний дүн, сургалтын байгууллагуудын чанарыг илтгэх мэдээллийн маягтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас МБСҮТ-тэй хамтран боловсруулж, батална.

2.6. Цогц сургалтын санхүүжилт, төлбөр

2.6.1. Сургалтын байгууллагатай байгуулах гэрээний санхүүжилт нь мэргэжлийн сургалт ба модульт сургалтын үр дүнд суурилсан санхүүжилт, суралцагчид олгох хоол, унааны хөнгөлөлт, чадамжийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрөөс бүрдэнэ. Мэргэжлийн сургалтын зардлыг тухайн сургалтын байгууллага тендерийн[31] бичиг баримтад санал болгосон нэг суралцагчид ногдох нэг долоо хоногийн буюу ажлын 5 өдрийн сургалтын үнийн саналаар[32], модульт сургалтын зардлыг нэг суралцагчид нэг өдөрт ногдох жишгээр[33], хоол, унааны хөнгөлөлтийг нэг суралцагчид нэг өдөрт олгох жишгээр[34], чадамжийн үнэлгээний төлбөрийг нэг суралцагчид ногдох жишиг зардлын сургалтын байгууллага хариуцах хэмжээгээр[35] тооцно.

2.6.2. Сургалтын байгууллагатай хийсэн гэрээний үр дүнд суурилсан санхүүжилтийн төлбөрийг дараах хуваарийн дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

---

[30] Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2017 оны 3 сарын 27-ны өдрийн А/50 тоот тушаалаар батлагдсан "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам"

[31] Аймаг, алслагдсан 3 дүүргийн хувьд энэ тушаалын 5-р хавсралтаар батлагдсан сургалт зохион байгуулах жишиг зардал

[32] Энэхүү тушаалын Тавдугаар хавсралтаар баталсан хэмжээнээс хэтрээгүй байна.

[33] Энэхүү тушаалын Зургаадугаар хавсралтаар модульт сургалтын зардлын жишгийг батлав.

[34] Энэхүү тушаалын Зургаадугаар хавсралтаар хоол, унааны хөнгөлөлтийн зардлын жишгийг батлав.

[35] Энэхүү тушаалын Долоодугаар хавсралтаар чадамжийн үнэлгээний төлбөрийн хэмжээг батлав.

2.6.2.1. Урьдчилгаа төлбөр буюу мэргэжлийн болон модульт сургалтын зардлын 50 хувийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ.

2.6.2.2. Явцын төлбөр буюу мэргэжлийн болон модульт сургалтын зардлын 20 хувийг мэргэжлийн сургалтын танхимын сургалт дуусч, сургалтын байгууллагаас явцын тайланг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шилжүүлнэ.

2.6.2.3. Эцсийн төлбөр буюу мэргэжлийн болон модульт сургалтын зардлын үлдэгдэл 30% хүртэлх хувийг төгсөгчдийн ур чадварын хөндлөнгийн үнэлгээ хийгдэж, сургалтын байгууллага төгсөгчдөд сургалтын дараах дэмжлэгийг 3 сарын турш үзүүлж, сургалтын үр дүнгийн эцсийн тайланг хүлээж авснаас хойш ажлын 15 хоногийн дотор шилжүүлнэ.

2.6.3. 2.6.2.3-т дурдсан мэргэжлийн болон модульт сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөрийн хэмжээг сургалтын үр дүнгийн биелэлттэй уялдуулж тооцно. Сургалтын үр дүн сургалтын байгууллагын тендерт оролцохдоо амлаж, гэрээнд тусгагдсан зорилтот түвшинд[36] хүрсэн бол сургалтын санхүүжилтийн үлдэгдэл 30 хувийг бүтнээр нь, хэрэв зорилтот түвшинд хүрээгүй бол үр дүнгийн зорилтот түвшин ба хүрсэн түвшний ялгааг 1.5 хувийн итгэлцүүрээр үржүүлсэн мөнгөн дүнг сургалтын санхүүжилтийн нийт дүнгээс хасч төлнө. Түүнчлэн, сургалтаас завсардсан, хасагдсан суралцагчдын сургалтанд суугаагүй өдрийн тоог[37] харгалзан тооцсон дүнг хасна. Мэргэжлийн болон модульт сургалтын эцсийн төлбөрийг тооцохдоо дараах томьёог ашиглана:

A. Мэргэжлийн болон модульт сургалтын зардал: ..... төг
B. Үр дүнгийн зорилтот түвшин (... %) ба хүрсэн түвшин (... %)-ний ялгаа: ..... %
C. Дээрх ялгааг 1.5 хувийн итгэлцүүрээр үржүүлсэн хувь: ..... %
D. Сургалтын үр дүн зорилтот түвшинд хүрээгүй тохиолдолд оногдуулж хасах дүн: $\frac{(A) \times (C)}{100}$ = ... төг.
E. Сургалтаас завсардсан суралцагч/дын сургалтын зардлаас хасч тооцох дүн:.....төг
F. Сургалтын зардлын эцсийн төлбөрийн хэмжээ: A - (Урьдчилгаа санхүүжилт) – (Явцын санхүүжилт) – D – E = ... төг.

2.6.4. Үр дүнд суурилсан санхүүжилтийн эцсийн төлбөрөөс хасагдах дүн эцсийн 30 хувийн төлбөрийн дүнгээс давсан тохиолдолд сургалтын байгууллагад нөхөн төлбөр тавихгүй. Гэвч тухайн сургалтын байгууллагыг дараа жилийн тендерт оролцуулахгүй.

2.6.5. Суралцагчийн хоол, унааны зардлын хөнгөлөлтийг суралцагчдын тухайн сарын ирцэд тулгуурлан, сар бүрийн 8-ны өдрийн дотор сургалтын байгууллагад шилжүүлнэ. Сургалтын байгууллага нь хоол, унааны зардлын хөнгөлөлтийг дансандаа авснаас хойш гурав хоногийн дотор суралцагчийн хувийн данс руу шилжүүлнэ. Банк хоорондын шилжүүлгийн суутгалыг суралцагч өөрөө хариуцна.

2.6.6. Суралцагчийг ажлын байрандаа дадлагажуулсан аж ахуйн нэгжид олгох урамшууллыг[38] гурван талт гэрээний биелэлтийг дүгнэсний үндсэн дээр аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь дадлагажуулалтын хөтөлбөр өндөрлөснөөс хойш нэг сарын дотор тухайн аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлнэ.

---

[36] Сургалтын байгууллага нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохдоо амласан хувь.

[37] Сургалтаас завсардсан, хассан тухай шийдвэрийг сургалтын байгууллага бичгээр үйлдсэн өдрөөс эхэлж тооцно.

[38] Энэхүү тушаалын Зургаадугаар хавсралтаар Аж ахуйн нэгжид олгох урамшууллын хэмжээг батлав.

2.6.7. Чадамжийн үнэлгээний нөхөн төлбөрийг төгсөгчдийн ур чадварын хөндлөнгийн үнэлгээ хийгдэж дууссаны дараа үнэлгээнд хамрагдсан суралцагчдын бодит тоонд үндэслэн, төгсөгчийн төлөх хэсгийг хасч тооцож шилжүүлнэ. Талууд тохиролцвол, уг төлбөрийг мэргэжлийн болон модульт сургалтын эцсийн төлбөртэй цуг шилжүүлж болно.

2.6.8. Хэрэв суралцагч төгсөлтийн дараах чадамжийн үнэлгээнд тэнцээгүй ч сургалтын байгууллагад эцсийн төлбөр шилжсэний дараа дахин үнэлүүлж тэнцсэн бол үнэлгээнийлцагч төгсөлтийн дараах чадамжийн үнэлгээнд тэнцээгүй ч сургалтын байгууллагад эцсийн төлбөр шилжсэний дараа дахин үнэлүүлж тэнцсэн бол онд үнд

2.7. Цогц сургалтын тоо мэдээ, тайлан, хяналт, үнэлгээ

2.7.1. Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын үйл ажиллагаанд, тухайлбал сургалтын байгууллага мэргэжлийн сургалтын чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр болон модульт сургалтуудын хөтөлбөрөө төлөвлөсөн ёсоор хэрэгжүүлж буй эсэх, сургалтыг мэргэжлийн багш зааж буй эсэх, дадлагажуулах хөтөлбөр зорилгын дагуу хэрэгжиж буй эсэх, хоол, унааны хөнгөлөлтийг суралцагчийн ирцтэй уялдуулан олгож буй эсэхэд хяналт, мониторинг хийхийн зэрэгцээ сургалтын байгууллага, хамтран ажиллагч аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай зөвлөгөө, чиглэл өгч ажиллана. Ийнхүү хяналт тавихдаа холбогдох Мэргэжлийн холбоодтой зохистой хэлбэрээр, үр дүнтэй, нэгдмэл зорилготой хамтарч ажиллана.

2.7.2. Сургалтын байгууллага нь суралцагчийн мэргэжлийн сургалт, модульт сургалт, ажлын байран дээрх дадлагын ирц, сургалтын үйл ажиллагаа, дадлагажуулах хөтөлбөрийн явцыг тогтмол хянана.

2.7.3. Сургалтын байгууллага нь суралцагчдын сар бүрийн ирцийн мэдээг харьяа аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад дараа сарын 3-ны дотор хүргүүлнэ.

2.7.4. Сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагааны явцын эхний тайланг мэргэжлийн сургалт дууссаны дараа, хоёр дахь тайланг ажлын байран дээрх дадлагажуулалт дууссаны дараа, эцсийн тайланг төгсөгчдийн ур чадварын хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулагдаж, төгсөгчдөд сургалтын дараах дэмжлэгийг 3 сарын турш үзүүлсний дараа аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлнэ.

2.7.5. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь сургалтад хамрагдах хүсэлт гаргах маягт, иргэнийг сонгох онооны үнэлгээний хуудас, сургалтад хамрагдахаар сонгогдсон иргэнд үзүүлсэн ажил мэргэжил, ажил эрхлэлтийн зөвлөгөөний үр дүнг баримтжуулах маягт, сургалтад хамрагдагчдын сэтгэл ханамжийн судалгааны маягт, сургалтын байгууллагын бүртгэл, хяналт, тайлангийн маягтуудыг боловсруулахын зэрэгцээ бүртгэл, тайланг цахим хэлбэрээр хүлээн авч, ашиглах техникийн боломж бүрдүүлэх асуудлыг хариуцаж, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сургалтын байгууллагуудыг удирдамж, чиглэлээр хангаж ажиллана.

2.8. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг хэрэгжүүлэх цагалбар

2.8.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг жил бүр дараах цагалбарын дагуу зохион байгуулна.

No:	Үйл ажиллагаа	Хэн хэрэгжүүлэх	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх газар	
				Нийслэл	Орон нутаг
1	Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чиглэлийг тодорхойлох	ХНХЯ	3-р сард багтаан	+	

2	Орон нутагт сургалт зохион байгуулах мэргэжлийн чиглэлийг ажил олгогч, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран тогтоох	Аймаг, алслагдсан 3 дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгуулага (ХЭБ)	5-р сард багтаан		+
3	Сургалтын талаар ажил хайгч болон олон нийтэд мэдээлэл хүргэх	Аймаг, нийслэл, дүүргийн ХЭБ	5 сараас 9-р сар хүртэл	+	+
4	Сургалтын байгууллагуудад сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл түгээх, сургалт зохион байгуулах	Нийслэлийн ХЭБ	5-р сард багтаан	+	
5	Сургалтын байгууллагыг сонгох нээлттэй тендер зарлах, шалгаруулах	Нийслэлийн ХЭБ	6-р сарын 1-нээс 9-р сарын 5-ны хооронд	+	
6	Орон нутагт сургалт зохион байгуулах ерөнхий санал гаргах	Аймаг, алслагдсан дүүргийн ХЭБ	9 сарын 1-ний дотор		+
7	Орон нутагт сургалт зохион байгуулах дэлгэрэнгүй төсөл боловсруулах	Аймаг, алслагдсан дүүргийн ХЭБ	10 сарын 1-ний дотор		+
8	Сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийг бүртгэх, онооны үнэлгээгээр сонгох	Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн ХЭБ	9-р сарын 20-ний дотор	+	+
9	Сургалтын төсвийн санал, хамрагдах иргэний тоо мэдээг ХХҮЕГ-т хүргүүлэх	Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн ХЭБ	9-р сарын 25-ны дотор	+	+
10	Сургалтын төсвийг аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн ХЭБ-д шилжүүлэх	ХХҮЕГ	10-р сарын 5-ны дотор	+	+
11	Сонгогдсон иргэдэд ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх	Аймаг, дүүргийн ХЭБ	10-р сарын 20-ний дотор	+	+
12	Сургалтын байгууллагатай гэрээ хийх, сургалтын санхүүжилтийн урьдчилгаа төлбөр шилжүүлэх	Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн ХЭБ	10-р сарын 15-ны дотор	+	+
13	Сургалтын байгууллага суралцагч нэг бүртэй гэрээ хийх	Сургалтын байгууллага	10-р сарын 20-ний дотор	+	+
14	Сургалт зохион байгуулах	Сургалтын байгууллага	11-р сараас дараа оны 3 -4 дүгээр сар	+	+
15	Сургалтын явцыг хянах	Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн ХЭБ	11-р сараас дараа оны 3-4 дүгээр сар	+	+
16	Сургалтын санхүүжилтийн явцын төлбөрийг шилжүүлэх	Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн ХЭБ	Мэргэжлийн сургалт дууссаны дараа	+	+
17	Чадамжийн хөндлөнгийн үнэлгээ	МБС-ын Үнэлгээний төв	3-5 дугаар сард багтаан	+	+
18	Төгсөгчдөд сургалтын дараах дэмжлэг үзүүлэх	Сургалтын байгууллага	3-4 дүгээр сараас 7-р дугаар сар	+	+
19	Гэрээний биелэлтийг дүгнэх, сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөрийг шилжүүлэх	Аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн ХЭБ	8 дугаар сард багтаан	+	+

2.9. Сургалтын байгууллагуудын чадавх бэхжүүлэх

2.9.1. Мэргэжлийн сургалтын байгууллагууд хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тэдний чадавхыг бэхжүүлэх дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.9.1.1. Цогц сургалтын зорилго, бүрэлдэхүүн, тавигдах шаардлага, үр дүнгийн үзүүлэлт, зорилтот түвшин, сургалтын байгууллагыг сонгон шалгаруулалт, сургалтын байгууллагатай байгуулах гэрээ, санхүүжилт, мэргэжлийн сургалтын чадамжид суурилсан хөтөлбөр, хөтөлбөрийн үнэлгээний төлөвлөгөө[39], модульт сургалтын хөтөлбөр, мэргэжлийн ба модульт сургалтын явцын ба үр дүнгийн хяналт, үнэлгээ, баталгаажуулалт зэрэг асуудлаар мэдээлэл, мэдлэгийг нь дээшлүүлэх сургалтыг сургалтын байгууллагуудын дунд нээлттэй сонгон шалгаруулалт зарлахаас 2 сараас доошгүй хугацааны өмнө аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зохион байгуулна.

2.9.1.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн сургалтын байгууллагын багш нарын ур чадвар, шинэ техник, технологи ашиглах мэдлэг, чадварыг нь дээшлүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэл дээрх сургалт, мөн насанд хүрэгчдэд заах арга зүйн сургалт зэргийг мэргэжлийн сургалтын байгууллагуудын захиалгаар холбогдох Мэргэжлийн холбоо, Бүсийн арга зүйн төв, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулж болно.

Гурав. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх удирдамж

Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь бичил бизнес эрхлэгчдэд зориулсан жижиг зээл, зээлийн өмнөх сургалт, зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ, тэдгээрт хамрагдах нөхцөлийн тухай мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон бусад арга хэрэгслийг ашиглан орон нутгийн хүн ам, зорилтот бүлгийн иргэдэд энгийн, ойлгомжтойгоор сурталчилж, түгээнэ. Шаардлагатай мэдээллийг казах иргэдэд зориулан төрөлх хэл дээр нь бэлтгэж түгээнэ.

3.1. Зээлийн өмнөх сургалт зохион байгуулах

3.1.1. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээл хүсэгчдэд зориулсан зээлийн өмнөх сургалтыг ХХҮЕГ-аас баталсан жишиг хөтөлбөрийн дагуу, сондгой тоотой сар бүрийн 15-ны өдрийн дотор зохион байгуулна. Зээлийн өмнөх сургалт нь зээл хүсэгчдийн бизнесийн санааг хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах ур чадварыг дээшлүүлэх, зээл болон зээлийн батлан даалтад хамрагдахад бүрдүүлэх баримт бичгүүд, зээлийн төслийг сонгон шалгаруулах аргачлал, зээлийн хүүгийн хөнгөлөлт зэргийг тайлбарлан таниулахад чиглэсэн 2 өдрийн сургалт байна.

3.2. Жижиг зээл олгох

3.2.1. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банк болон жижиг зээлийн төслийг шалгаруулахад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулах аргачлал, жижиг зээлийн хүүгийн түвшин тогтоох аргачлал, жижиг зээлийн хөрөнгийг аймаг, дүүрэгт хуваарилах аргачлал, жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх банктай байгуулах гэрээний загвар зэрэг асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

---

[39] Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын чадамжид суурилсан мэргэжлийн сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийн үнэлгээний төлөвлөгөө, модульт сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр сургалтыг зохион байгуулахад Мэргэжлийн боловсрол сургалтын арга зүйн төв, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв голлох үүрэгтэй оролцоно.

3.2.2 Жижиг зээлийг нийслэлийн бүх дүүрэг, 21 аймгийн төвд оршин суудаг иргэдэд олгох чиглэл баримтална. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээлийг сумын оршин суугч авах тохиолдолд зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдах унааны болон холбогдох бусад зардлыг зээлдэгч өөрөө хариуцна.

3.2.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жижиг зээл хүсэгчдийн төслийг урьдчилан шалгаруулахдаа төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг батлагдсан маягтын дагуу[40] үнэлнэ.

3.2.4. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь оролцогч банкнаас жижиг зээлийн хэрэгжилтийн талаар явцын тайланг батлагдсан маягтын дагуу 6 сар тутамд авна. Оролцогч банкны гаргах явцын тайлангийн маягтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална.

3.3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг зохион байгуулах

3.3.1. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний зардлын төсвийг аймаг, дүүрэгт хуваарилахдаа энэхүү хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээлийн хөрөнгийг аймаг, дүүрэгт хуваарилсан хэмжээ, хамрагдах хүний тоог харгалзан тогтооно.

3.3.2. Зээлийн дараах санхүүгийн бус дэмжлэгийг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ баталсан зардлын жишгийг[41] баримтална.

3.3.3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтад дараах шаардлага хангасан байгууллага оролцоно. Үүнд:

3.3.3.1. Бизнес хөгжлийн сургалт зохион байгуулах, эсвэл зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий,

3.3.3.2. Сүүлийн гурван жилийн хугацаанд бизнес хөгжлийн чиглэлийн сургалт, зөвлөгөө өгөх, эсвэл менторингийн үйл ажиллагаа тогтмол, үр дүнтэй явуулсан,

3.3.3.3. Бизнес хөгжлийн сургалтын нэр бүхий болон туршигдсан хөтөлбөрүүдтэй, 3-аас доошгүй жил бизнес хөгжлийн сургалт, зөвлөгөө өгсөн бодит туршлага бүхий багштай[42],

3.3.3.4. Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, менторинг хийх бодит туршлагатай зөвлөхүүдтэй буюу ийм зөвлөхүүдтэй хамтран ажилладаг.[43]

3.3.4. Дээрх үндсэн шаардлага бодитой хангагдсан эсэхийг холбогдох бичиг баримтыг судалж, газар дээр нь танилцаж, дүгнэсний үндсэн дээр дараах шалгуур үзүүлэлтийг ашиглан зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг гүйцэтгэх байгууллагыг эцэслэн шалгаруулна. Үүнд:

3.3.4.1. Бизнес хөгжлийн сургалтын хөтөлбөрүүд нь бичил бизнес эрхлэгчдийн хэрэгцээнд нийцсэн, ажлын 7-оос доошгүй өдрийн хөтөлбөр[44]-тэй байх,

3.3.4.2. Бизнесийн зөвлөгөө, менторингийн үйлчилгээ үзүүлж байсан туршлага нь бусад байгууллагуудаас илэрхий давуу байх,

3.3.4.3. Бизнес хөгжлийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд хоёр сарын хугацааны мөчлөг бүрт хамруулж чадах хүний тоо,

3.3.4.4. (21 аймгийн хувьд) Тухайн орон нутагт тогтмол үйл ажиллагаа явуулдаг байгууллага байх.

---

[40] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах тухай" тушаалын долоодугаар хавсралтаар батлав.

[41] Энэхүү тушаалын Аравдугаар хавсралтаар санхүүгийн бус үйлчилгээний зарлын хэмжээг батлав.

[42] Хөтөлбөр болон мэргэжил, ур чадвар, ажлын туршлагыг харуулсан анкетыг хавсаргана.

[43] Бизнесийн хөгжлийн зөвлөхүүдийн мэргэжил, ур чадвар, ажлын туршлагыг харуулсан анкетыг хавсаргана

[44] Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын "Бизнесээ эхэл" сургалтын хөтөлбөрт суурилсан, түүнээс сайжруулсан хөтөлбөр байх.

3.3.5. Бизнесийн зөвлөх байгууллагуудын холбоо, нийгэмлэгийн гишүүн байх нь сонгон шалгаруулалтын үед харгалзаж үзэх давуу тал болно.

3.3.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоог урьдчилан төлөвлөсний үндсэн дээр сонгон шалгаруулалтын хугацааг хөтөлбөрийн хүрээнд олгох жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагаа эхлэхтэй уялдуулан зарлана. Үйлчилгээнд хамрагдах иргэний тоог харгалзан шаардлагатай бол нэгээс олон байгууллагыг сонгож болно.

3.3.7. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сонгон шалгаруулалтын шийдвэр, дэлгэрэнгүй үндэслэлийг ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор байгууллагынхаа цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад арга хэрэгслээр олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

3.3.8. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хариуцан гүйцэтгэхээр сонгон шалгаруулсан байгууллагатай аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь гэрээ[45] байгуулж ажиллана. Хэрэв санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдах зээлдэгчдийн тоо анх төлөвлөж, гэрээнд тусгасан тооноос хэтрэхээр бол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг зээлдэгчид гурван сарын хугацаанд үзүүлэх учир сонгосон байгууллагатай байгуулах гэрээний үргэлжлэх хугацаа 15 сар хүртэл байж болно.

3.3.9. Бизнес хөгжлийн сургалт нь жишиг хөтөлбөрийн дагуу нийт ажлын 7 өдрөөс багагүй хугацаатай, 50-иас доошгүй цагийн хөтөлбөртэй, бизнес загварыг сайжруулахад чиглэсэн бизнесийн хурдасгуурын сургалтыг багтаасан байна. Сургалтын жишиг хөтөлбөрийг ХХҮЕГ баталж, мөрдүүлнэ.

3.3.10. Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ тухайн иргэний хэрэгцээнд үндэслэн 20-30 цагийн хугацаатай байна. Бизнес менежментийн чиглэлээрх менторийн үйлчилгээг аль болохоор амжилттай бизнес эрхлэгчээр үзүүлэхэд анхаарч, бизнес менежментийн нэг ментort нэг сард оногдох үйлчлүүлэгчийн тоог 5-аас хэтрүүлэхгүй. Ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, сайжруулалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээг багавтар бүлгээр зохион байгуулж болно.

3.3.11. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээлдэгчдийн нэрсийн жагсаалт[46], холбогдох мэдээллийг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллагад сар бүрийн 15-ны өдрөөр тасалбар болгож хүргүүлнэ.[47]

3.3.12. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллага хамтарч зээлдэгч бүрийн санхүүгийн бус үйлчилгээний хэрэгцээ, зорилтот үр дүнг тодорхойлж, иргэн бүртэй гурван талт гэрээ[48] байгуулж, хэрэгжилтийг нь дүгнэж ажиллана.

3.3.13. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний үед зээлдэгчдийн хэрэгжүүлж буй бичил бизнесийн үйл ажиллагааны байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хязгаарлаж, бууруулж буй байдалд хяналт тавьж, зөвлөгөө өгөхийн зэрэгцээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар хангаж ажиллана. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны холбогдох газар нь жижиг зээл авсан иргэдийн аж ахуйн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг түгээмэл салбар, үйл ажиллагааны чиглэлүүдээр боловсруулж нэвтрүүлнэ.

---

[45] Энэхүү тушаалын Наймдугаар хавсралтаар гэрээний загварыг батлав.

[46] Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд жижиг зээлийг дамжуулан зээлдүүлэхээр сонгон шалгуруулсан банкнаас жижиг зээл авсан иргэн

[47] Гэрээ байгуулсны дараах эхний жагсаалтыг энэ хуваарийг үл харгалзан яаралтай хүргүүлнэ.

[48] Энэхүү тушаалын Есдүгээр хавсралтаар гурван талт гэрээний загварыг батлав.

3.3.14. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний явц, үр дүнд хяналт, мониторинг хийнэ.

3.3.15. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг[49] зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдсаны төгсгөлд цахимаар авч, дүнг нэгтгэн, өөрийн байгууллагын болон хамтран ажиллагч банк, санхүүгийн бус үйлчилгээг гүйцэтгэгч байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад анхаарч ажиллана.

3.3.16. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйл ажиллагааны тайланг гэрээ байгуулсан өдрөөс хойш 2 сар тутамд, эцсийн хугацааны болон нэгдсэн тайланг гэрээний хугацаа дууссанаас хойш нэг сарын дотор аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлнэ.

3.3.17. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний санхүүжилтийг гэрээ байгуулсан өдрөөс хойш 2 сар тутамд, үйлчилгээнд бүрэн хамрагдан, 3 талт гэрээг хамтран дүгнэсэн зээлдэгчдийн тоонд үндэслэж, үйл ажиллагааны тайланг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногт багтаан шилжүүлнэ.

3.3.18. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний бүртгэл, хяналт, тайлангийн маягтууд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын тушаалаар батална. Түүнчлэн зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, үйл ажиллагааны явцын хөтлөлт, тайланг хөтөлбөрт оролцогч байгууллагаас цахим хэлбэрээр хүлээж авна.

3.4. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хариуцан гүйцэтгэх байгууллагуудын чадавх бэхжүүлэх

3.4.1. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн байгууллага орон нутагт хомсдолтой тохиолдолд энэ чиглэлээр мэргэших сонирхолтой, тодорхой хэмжээний туршлагатай, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг чадавх бэхжүүлэх сургалтад хамруулсны дараа сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Уг сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.

3.4.2. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын менторуудын чадавхыг дээшлүүлэх сургалтыг жилд нэг удаа зохион байгуулж болно. Уг сургалтыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлнэ.

Дөрөв. Зорилтот бүлгийн иргэдийн тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих орон нутгийн санаачилгын төсөл хэрэгжүүлэх удирдамж

4.1. Орон нутгийн санаачилгын төсөлд тавигдах шаардлага, шалгаруулалт

4.1.1. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь орон нутаг дахь ажилгүйдэл, ядуурал, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, зорилтот бүлгийн иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр төслийн баримт бичгийг боловсруулж, орон нутаг дахь Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжүүлсэн байна.

4.1.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь аймаг, нийслэл дүүргийн санаачилсан төслийг дараах үзүүлэлтийг ашиглан онооны үнэлгээний аргаар дүгнэж, шалгаруулна. Үүнд:

---

[49] Уг судалгаагаар зээлийн өмнөх сургалт, жижиг зээл олгох үйл ажиллагаа, зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийг судална.

4.1.2.1. Төсөл хэрэгжсэнээр хөдөлмөрийн зах зээлд оролцоход илүү бэрхшээлтэй тулгарч буй залуучууд, эмэгтэйчүүд, ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажилтай, орлоготой болгоход бодит хувь нэмэр оруулах магадлал,

4.1.2.2. "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-ийн долоодугаар зүйлд дурдсан арга хэмжээ болон бусад шинэлэг стратеги, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байдал,

4.1.2.3. Төсөлд тухайн орон нутаг ач холбогдол өгч, орон нутгийн төсвөөс хөрөнгө хуваарилахаар төлөвлөсөн байдал,

4.1.2.4. Төслийг хэрэгжүүлэхэд ажил олгогч, хувийн хэвшилтэй хэр өргөн хүрээнд хамтран ажиллахаар төлөвлөсөн байдал,

4.1.2.5. Төслийн үр дүнгийн суурь ба зорилтот түвшинг тодорхойлсон, үр дүнг тооцох аргачлалаа боловсруулсан байдал,

4.1.2.6. Төсвийн зардлыг бодитой, нэгжийн үнэлгээний үндэслэлтэй, сайн задаргаатай тооцсон байдал,

4.1.2.7. Төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах байгууллагуудыг сонгосон, хэрэгжилтийн явцад шударга, ил тод байдлыг хангаж ажиллах байдал,

4.1.2.8. Төсөл хэрэгжсэнээр үр шим хүртэх иргэдийн тоо,

4.1.3. Орон нутгийн ХЭБ нь Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн 7.4-т заасан үйл ажиллагааны чиглэлийг баримтлахдаа одоо хэрэгжүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, үйл ажиллагаатай давхцаагүй шинэлэг үйлчилгээ, үйл ажиллагааг тусгасан байна. Түүнчлэн, нэг төслийн хүрээнд хоорондоо уялдаагүй өөр өөр чиглэлийн үйл ажиллагааг багтаахгүй.

4.1.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь орон нутгийн санаачилсан төслийн сонгон шалгаруулалтыг жил бүрийн 11 дүгээр сард багтаан зохион байгуулна. Сонгон шалгаруулах ажлын хэсэгт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Монгол Улсын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн нэгж, холбогдох хөндлөнгийн төрийн бус байгууллагын төлөөллийг оруулна.

4.1.5. Төслийн сонгон шалгаруулалтыг бүх орон нутгийн ХЭБ-ын дунд нэгэн зэрэг нээлттэйгээр зохион байгуулна. Ингэхдээ орон нутгийн ХЭБ-ууд нь өөрсдөө хүсвэл, төслөө ажлын хэсгийн болон бусад орон нутгийн ХЭБ-уудын өмнө танилцуулах боломжтой байхаар зохион байгуулна.

4.2. Орон нутгийн санаачилгын төслийн хэрэгжилт, хяналт

4.2.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус хэвшилд ажиллагчдад[50] зориулсан ур чадварын сургалтыг иргэдийн бодит хэрэгцээнд нийцүүлэн, практик агуулгатай модульчилсан хөтөлбөр ашиглаж, ажлын 10 өдрөөс дээшгүй хугацаатай зохион байгуулна. Сургалтыг зохион байгуулахдаа одоо мөрдөгдөж буй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардлын жишгийг[51] мөрдөнө.

4.2.2. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, албан бус хэвшилд ажиллагчдад зориулсан ур чадварын богино хугацааны, практик сургалтыг сургалтын эрх бүхий байгууллагыг шалгаруулж, гэрээгээр гүйцэтгүүлнэ. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас баталсан эрх бүхий, мэргэжлийн сургалт зохион байгуулах шаардлага хангасан сургалтын байгууллагын жагсаалтад орсон байгууллагуудаас дараах шаардлага, нөхцөлийг хангасан байгууллагыг сонгож шалгаруулна. Үүнд:

4.2.3. Сүүлийн хоёр жилийн хугацаанд тухайн мэргэжил, ур чадварын чиглэлийн сургалтын үйл ажиллагаа тогтмол явуулсан,

---

[50] Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжигдсэн богино хугацааны мэргэжлийн сургалт, давтан сургалтад сүүлийн хоёр жилийн хугацаанд хамрагдаж байгаагүй иргэн мөн эсэхийг тогтоосны үндсэн дээр энэхүү богино хугацааны модульт сургалтад хамруулна.

[51] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А\18 тоот тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан.

4.2.3.1. Тухайн чиглэлийн ур чадварын модульт, практик сургалтын хөтөлбөртэй[52],

4.2.3.2. Ур чадварын модульт сургалтыг заах мэргэшсэн багштай, уг багш нь насанд хүрсэн хүнд заах арга зүй эзэмшсэн[53],

4.2.3.3. Тухайн орон нутагт сургалтын үйл ажиллагаа явуулдаг байгууллага байх.

4.2.4. Аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн сургалт\уудыг гүйцэтгэх сургалтын байгууллагыг урьдчилсан байдлаар шалгаруулж, шалгаруулсан үндэслэлээ төслийн баримт бичигт тусгасан байна.

4.2.5. Орон нутгийн санаачилгын төслийг төлөвлөсөн стратеги, хугацааны дагуу хэрэгжүүлнэ.

4.2.6. Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь төсөл хэрэгжүүлэх хугацаанд хуримтлуулсан туршлага, сургамж, бодлогын үр нөлөөний талаар дэлгэрэнгүй тайлагнана. Орон нутгийн санаачилгын төсөл нь ажилгүйдлийг бууруулах, ажилгүйдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, шинэлэг арга хэмжээг туршиж, үр нөлөөг нь тогтоох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой тул орон нутгийн санаачилгын төслийн хэрэгжилтийг тайлагнаж, дүгнэхэд үүнийг онцгойлон анхаарна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь орон нутгийн тайланд нэгдсэн дүн шинжилгээ хийж, гарсан үр дүн, сургамж, бодлогын үр нөлөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тайлагнана.

4.2.7. Төсөл хэрэгжүүлэх хугацаа дууссанаас хойш үйл ажиллагаа үргэлжлэх тохиолдолд зардлыг хөтөлбөрөөс санхүүжүүлэхгүй.

4.2.8. Төслийн хэрэгжилт удааширсан болон бусад үндэслэлээр төсөл хэрэгжүүлэх гэрээний[54] хугацааг сунгахгүй.

4.2.9 Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр, эрхлэлтийн байгууллага нь төслийн хэрэгжилтийн ба явцын санхүүгийн тайланг төсөл эхэлснээс хойш хагас жил тутам, төслийн эцсийн тайланг төслийн хугацаа дууссанаас хойш хоёр сарын дотор холбогдох маягтын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ.

4.2.10 Төслийн батлагдсан санхүүжилтийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэд дансанд төслийн хэрэгжилтийн хугацааг харгалзан дараах хуваарийн дагуу шилжүүлнэ. Үүнд:

4.2.10.1. Урьдчилгаа төлбөрийн хэмжээ төслийн нийт төсвийн 30 хувиас хэтэрч болохгүй. Урьдчилгаа төлбөрийг гэрээнд гарын үсэг зурсны дараа шилжүүлнэ.

4.2.10.2. Явцын төлбөрийг хагас жил тутмын хэрэгжилтийн явцын тайланг хүлээж авсны дараа шилжүүлнэ. Төслийн тайлант хугацааны мөчлөгийн тоог харгалзан явцын төлбөрийн хэмжээг тогтооно.

4.2.10.3. Эцсийн төлбөрийн хэмжээ нь төслийн нийт төсвийн 10 хувиас доошгүй байна. Уг төлбөрийг төслийн үйл ажиллагааны сүүлчийн тайлант хугацааны тайлан болон аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, олон нийтэд ил тод танилцуулсан эцсийн нэгдсэн тайланг хүлээж авснаас хойш бодит зардалд үндэслэж шилжүүлнэ.

---

[52] Сургалтын хугацаа, суралцагчдын хэрэгцээтэй уялдуулан модульт хөтөлбөрөө сайжруулсан, нийцүүлсэн

[53] Мэргэжил, ур чадвар, ажлын туршлагыг харуулсан анкетыг хавсаргана.

[54] Энэхүү тушаалын Арван нэгдүгээр хавсралтаар гэрээний загварыг батлав.

4.2.11. Төслийн үйл ажиллагааны явцын болон эцсийн тайлан бүрт зардлын тайланг хавсаргана. Орон нутгийн төсвөөс болон бусад эх үүсвэрээс хамтран санхүүжүүлсэн бол зардлыг эх үүсвэрээр ялгаж харуулсан байна.

4.2.12. Туршилтын хөтөлбөрийн 7.5.5-д заасан захиргааны зардалд гэрээгээр авч ажиллуулах ажилтны цалин хамаарахгүй бөгөөд энэ ажилтны цалингийн хэмжээ нь ХЭБ-ын холбогдох ажилтны цалингаас ихгүй байна. Туршилтын хөтөлбөрийн 7.5.5-д заасан захиргааны зардал болон гэрээт ажилтны цалингийн зардлын нийт хэмжээ орон нутгийн санаачилгын төслийн санхүүжилтийн 20 хувиас хэтрэхгүй байна.

4.2.13. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь орон нутгийн санаачилгын төслийн тайлангийн загварыг боловсруулахдаа төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, тэдгээрт хамрагдагсдын талаарх тайланг дэлгэрэнгүй авахад анхаарна.

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын
сайдын 2019 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн 38 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

Мэргэжлийн сургалтын байгууллагатай байгуулах үр дүнд суурилсан санхүүжилтийн гэрээний загвар

..... хот /дүүрэг/аймаг № ... 20... оны ... сарын ... өдөр

Энэхүү гэрээг ..... аймаг, нийслэл, алслагдсан дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (цаашид ХЭБ гэх) болон ..... мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (цаашид сургалтын байгууллага гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-т (цаашид хөтөлбөр гэх) заасан хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг (цаашид цогц сургалт гэх) зохион байгуулахтай холбогдуулан дараах зүйлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтаар суралцагчид тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэргэшлийн II түвшний чадамжийн бүх нэгжийг багцаар нь эзэмшүүлэх, суралцагчийн хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дээшлүүлэх, улмаар суралцагчийн тогтвортой ажил эрхлэх боломж, чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

1.2. Суралцагчдын нэрсийн жагсаалт энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

1.3. Төгсөлтийн дараах хөндлөнгийн үнэлгээгээр тухайн мэргэжлийн мэргэшлийн II түвшний чадамжийн бүх нэгжийг эзэмшсэн нь баталгаажиж, гэрчилгээ авсан төгсөгчийн нийт суралцагчдын тоонд эзлэх хувиар сургалтын үр дүнг тооцно. Энэхүү гэрээнд хамаарах сургалтын үр дүнгийн зорилтот түвшин ..... хувиас[55] доошгүй байна.

1.4. Сургалтын үр дүнгийн зорилтот түвшин биелсэн бол сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөрийг бүтэн олгоно. Үр дүнгийн зорилтот түвшин бүрэн биелээгүй бол сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөрийг холбогдох аргачлалын дагуу хасч тооцно.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх, үүрэг

2.1. Сургалтад хамрагдсан суралцагчийн талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.2. Сургалтын санхүүжилтийг сургалтын байгууллагад энэхүү гэрээний дөрөвдүгээр зүйлд заасанчлан шилжүүлнэ.

2.3. Сургалтад хамрагдах иргэний дэлгэрэнгүй бүртгэлийг сургалт эхлэхээс өмнө сургалтын байгууллагад хүргүүлнэ.

2.4. Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, сургалтын байгууллагыг арга зүйгээр ханган, сургалтын явцын ба эцсийн тайлан, суралцагчдын ирцийн мэдээг тогтсон хугацаанд батлагдсан маягтын дагуу хүлээж авна.

2.5. Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажиллах аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг сургалтын байгууллагаас ирүүлснийг ажлын 15 хоногт

[55] Сургалтын байгууллага сонгон шалгаруулалтанд оролцохдоо амласан түвшин

багтаан хянаж, гурван талт гэрээ[56] байгуулахыг зөвшөөрөх эсэх шийдвэрээ сургалтын байгууллагад бичгээр мэдэгдэнэ. ХЭБ нь шийдвэрээ суралцагчдыг ажлын байран дээр дадлагажуулах ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн хугацаанаас өмнө сургалтын байгууллагад бичгээр мэдэгдсэн байна. Сургалтын байгууллага, сургалтаас завсардсан иргэний сургалтын зардлыг гэрээний санхүүжилтийн төлбөрөөс зохих хувь хэмжээгээр хасч тооцно.

2.6. Сургалтын санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан бол сургалтын байгууллагаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авах эрхтэй.

Гурав. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

3.1. ..... мэргэжлийн сургалтыг ..... оны ..... сарын .... -ны өдрөөс .... оны .....сарын .....-ны өдөр хүртэл (нийт ..... долоо хоногийн хугацаатай) нийт ..... (тоо) иргэдийг хамруулан зохион байгуулна.

3.2. Сургалтын үр дүнг дээшлүүлэх, суралцагчийн хандлага, оролцоог нэмэгдүүлэхийн тулд суралцагч бүртэй гэрээ байгуулж ажиллана.

3.3. Сургалтыг туршилтын хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх удирдамжид заасан шаардлагын дагуу, чанартай зохион байгуулна.

3.4. Суралцагч сургалтад дур сонирхолтой ирэх, хамтран суралцагчидтайгаа ойлголцож, бие биенээ дэмжсэн, нэг баг, хамт олон болж суралцах эрмэлзлийг өдөөсөн эерэг, таатай орчныг бүрдүүлж ажиллана.

3.5. Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажиллах аж ахуйн нэгжүүдийг зохих шалгуурын дагуу урьдчилан сонгож, ХЭБ-д бичгээр мэдэгдэж, танилцуулна.

3.6. ХЭБ-аас зөвшөөрсний үндсэн дээр аж ахуйн нэгжтэй гурван талт гэрээ байгуулна. Тухайн аж ахуйн нэгжтэй хамтран ажлын байран дээрх дадлагжуулалтаас хүлээх үр дүнг суралцагч бүрээр тодорхойлж, гурван талт гэрээнд хавсаргана.

3.7. Гурван талт гэрээний биелэлтэд хяналт тавьж, аж ахуйн нэгж болон суралцагчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж, дадлагажуулах хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэхийн төлөө ажиллана.

3.8. Суралцагчийн ирцийн бүртгэлийг өдөр тутамд үнэн зөв хөтөлж, ирцийн бүртгэлийг сар бүрийн сүүлчийн өдрөөр тасалбар болгон ХЭБ-д дараа сарын 3-ны дотор хүргүүлнэ. Суралцагчдын хоол, унааны зардлын хөнгөлөлтийг ХЭБ-аас хүлээж авснаас хойш 3 хоногийн дотор суралцагчдын хувийн дансанд шилжүүлж, баримтыг хадгална. Суралцагч ажлын байран дээр дадлагажих үеийн ирцийн бүртгэлийг хамтран ажиллаж буй аж ахуйн нэгжээр хөтлүүлж, ХЭБ-д хүргүүлнэ. Ажлын байран дээрх дадлагын үеэр суралцагчдын ирцэд хяналт тавина.

3.9. Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэргэжлийн сургалт, модульт сургалт, ажлын байран дээрх дадлагыг нийт 2 долоо хоногоос дээш хугацаагаар тасалсан бол сургалтаас хасна. Сургалтаас завсардаж, хасагдсан суралцагч/дын нэр, хасагдсан шалтгаан, өдрийг тодорхой дурдсан мэдээллийг сар бүрийн сүүлчийн өдрөөр тасалбар болгож ХЭБ-д албан бичгээр хүргүүлнэ.

3.10. Мэргэжлийн сургалтын танхимын сургалтын дадлагын үед болон ажлын байран дээрх дадлагын үед суралцагчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар тасралтгүй хангана.

3.11. Төгсөгчийн чадамж, мэргэжлийн ур чадварын хөндлөнгийн үнэлгээг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвөөр гүйцэтгүүлнэ.

3.12. Төгсөгчийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд урьдчилан төлж, холбогдох баримтыг ХЭБ-д хүргүүлнэ.

---

[56] Сургалтын байгууллага, аж ахуйн нэгж, аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын хооронд байгуулах гэрээ

3.13. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр шаардлагатай дэмжлэгийг сургалт дууссанаас хойш 3 сарын туршид үзүүлнэ.

3.14. Төгсөгчдийн ажил эрхлэлтийн мөшгих судалгааг төгсөлтөөс хойш 6 сарын дараа өөрийн зардлаар явуулж, харьяа аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлнэ.

3.15. Сургалтын хэрэгжилтийн тайланг баталсан маягтын дагуу ХЭБ-д дараах хугацаанд ирүүлнэ. Үүнд:

3.15.1. Явцын тайлан 1: .... оны .... сарын ....-ны дотор (мэргэжлийн сургалт дууссаны дараа)

3.15.2. Явцын тайлан 2: .... оны .... сарын ....-ны дотор (ажлын байран дээрх дадлага дууссаны дараа)

3.15.3. Эцсийн тайлан: .... оны ..... сарын .....-ны дотор (төгсөгчдийн хөндлөнгийн үнэлгээ хийгдэж, сургалтын дараах 3 сарын турш төгсөгчдийг дэмжих үйлчилгээ үзүүлсний дараа)

3.16. Гэрээний дагуу олгох санхүүжилтийг гэрээний Дөрөв дэх хэсэгт заасан хугацаанд шилжүүлэхийг ХЭБ-аас нэхэмжлэх, шаардах эрхтэй.

Дөрөв. Цогц сургалтын гэрээний санхүүжилт, төлбөр

4.1. Гэрээний санхүүжилтийн дээд хэмжээ ..... /...../ төгрөг байна. Үүнээс:

4.1.1. Мэргэжлийн сургалтын зардал[57]: ажлын 5 өдрийн сургалтад нэг суралцагчид ногдох зардал - ..... төгрөг, нийт ..... хүртэлх төгрөг;

4.1.2. Модульт сургалтуудын зардал[58]: нэг суралцагчид ногдох зардал - .....төгрөг, нийт ..... хүртэлх төгрөг;

4.1.3. Суралцагчид олгох хоол, унааны зардлын хөнгөлөлт[59]: нэг суралцагчид нэг өдөрт ..... төгрөг, нийт..... хүртэлх төгрөг;

4.1.4. Төгсөгчийн чадамжийн үнэлгээний төлбөр[60]: нэг суралцагчид .....төгрөг, нийт..... хүртэлх төгрөг.

4.2. Сургалтын байгууллагад олгох санхүүжилтийг тухайн байгууллагын ..... банкны ..... тоот дансанд шилжүүлнэ.

4.3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын байгууллагаас ирүүлсэн суралцагчдын сар бүрийн ирцийн бүртгэлд үндэслэн суралцагчдын хоол, унааны зардлын хөнгөлөлтийг сургалтын байгууллагад сар бүрийн 8-ны дотор шилжүүлнэ.

4.4. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь сургалтын үр дүнд суурилсан санхүүжилтийг дараах хуваарь, нөхцөлийн дагуу сургалтын байгууллагад шилжүүлнэ:

4.4.1. Урьдчилгаа төлбөр болох мэргэжлийн ба модульт сургалтын санхүүжилтийн 50% буюу ..... /...../ төгрөгийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш ажлын 5 хоногийн дотор;

4.4.2. Явцын төлбөр болох мэргэжлийн болон модульт сургалтын санхүүжилтийн 20%- буюу ..... /...../ төгрөгийг мэргэжлийн сургалтын танхимын сургалт дуусч, сургалтын байгууллагаас явцын тайлан 1-ийг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор;

---

[57] Сургалтын байгууллага тендерт оролцохдоо санал болгосон үнэ

[58] Хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын сургалт; компьютер, цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт; хувь хүний санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтын зардал. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан жишгийг баримтална.

[59] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан зардлын жишгийг баримтална.

[60] Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан зардлын жишгийг баримтална.

4.4.3. Эцсийн төлбөр болох мэргэжлийн болон модульт сургалтын зардлын 30% хүртэлх хувийг сургалтын байгууллагын эцсийн тайланг хүлээж авснаас хойш ажлын 15 хоногийн дотор.

4.5. Хэрэв сургалтын үр дүн зорилтот түвшин буюу ..... %-д[61] хүрсэн нь хөндлөнгийн үнэлгээгээр баталгаажсан бол сургалтын зардлын үлдэгдэл 30% буюу ..... төгрөгийг сургалтын байгууллагад бүтэн шилжүүлнэ.

4.6. Хэрэв сургалтын үр дүн зорилтот түвшин буюу ..... %-д хүрээгүй бол, сургалтын үр дүнгийн зорилтот түвшин ба хүрсэн түвшний ялгааг 1.5 хувийн итгэлцүүрээр үржүүлсэн мөнгөн дүнг сургалтын санхүүжилтийн нийт дүнгээс хасч шилжүүлнэ. Түүнчлэн, сургалтаас завсардсан суралцагчийн сургалтанд суугаагүй өдрийн тоог[62] харгалзан сургалтын эцсийн төлбөрийн хэмжээнээс хасч тооцно. Мэргэжлийн болон модульт сургалтын эцсийн төлбөрийг тооцохдоо дараах томьёог ашиглана:

A. Мэргэжлийн болон модульт сургалтын зардал: ..... төгрөг
B. Үр дүнгийн зорилтот түвшин (... %) ба хүрсэн түвшин (... %)-ний ялгаа: ..... %
C. Дээрх ялгааг 1.5 хувийн итгэлцүүрээр үржүүлсэн хувь: ..... %
D. Сургалтын үр дүн зорилтот түвшинд хүрээгүй тохиолдолд оногдуулж хасах мөнгөн дүн: $\frac{(A) \times (C)}{100}$ = ... төгрөг.
E. Сургалтаас завсардсан суралцагч/дын сургалтын зардлаас хасч тооцох дүн:.....төгрөг
F. Сургалтын зардлын эцсийн төлбөрийн хэмжээ: A - (Урьдчилгаа санхүүжилт) – (Явцын санхүүжилт) – D – E = ... төгрөг

4.7. Үр дүнд суурилсан санхүүжилтийн эцсийн төлбөрөөс хасагдах дүн эцсийн 30 хувийн төлбөрийн дүнгээс давсан тохиолдолд сургалтын байгууллагад нөхөн төлбөр тавихгүй. Гэвч тухайн сургалтын байгууллагыг дараа жилийн тендерт оролцуулахгүй

4.8. Чадамжийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрийг төгсөгчдийн ур чадварын хөндлөнгийн үнэлгээ хийгдэж дууссаны дараа, үнэлгээнд хамрагдсан суралцагчдын бодит тоонд үндэслэн, үнэлгээний төлбөрийн төгсөгчийн төлөх хэсгийг хасч, сургалтын байгууллагаас ирүүлсэн төлбөрийн хүсэлтийг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор сургалтын байгууллагын дансанд шилжүүлнэ[63].

4.9. Хэрэв сургалтын санхүүжилтийн эцсийн төлбөр хийгдсэний дараа төгсөгч/ид чадамжийн хөндлөнгийн үнэлгээнд дахин хамрагдаж тэнцэж, мэргэшлийн II түвшний багц чадамж эзэмшсэнээ баталгаажуулсан бол үнэлгээний төлбөрийг сургалтын байгууллагад нөхөж олгохгүй.

Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээ нь .... оны .... сарын ....-ны өдрөөс .... оны .... сарын ....-ны өдөр хүртэл хүчинтэй. Гэрээний хугацаанд өөрчлөлт оруулах хүсэлтээ аль нэг тал нь гэрээний хугацаа дуусахаас гурван долоо хоногоос доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдсэний үндсэн дээр талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

5.2. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Шийдвэрлэх боломжгүй маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

---

[61] Сургалтын байгууллага нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохдоо амласан үр дүнгийн зорилтот түвшин.

[62] Сургалтаас завсардсан, хассан тухай шийдвэрийг сургалтын байгууллага бичгээр үйлдсэн өдрөөс эхлэн тооцно.

[63] Талууд тохиролцвол, уг төлбөрийг мэргэжлийн болон модульт сургалтын эцсийн төлбөртэй цуг шилжүүлнэ гэж гэрээнд тусгаж болно.

5.3. Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээний аль ч хувь нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан талууд

А талыг төлөөлж:
..... Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга ..... /нэр/
..... /гарын үсэг, тамга/
Хаяг: .....

Сургалтын байгууллагыг төлөөлж:
..... Сургалтын байгууллагын захирал ..... /нэр/
..... /гарын үсэг, тамга/
Хаяг: .....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн 2/33 дугаар тушаалын
Гуравдугаар хавсралт

Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтад хамрагдах тухай гэрээний загвар

20..... оны ..... сарын ....өдөр №..... ..... аймаг/дүүрэг

Энэхүү гэрээг нэг талаас ..... /цаашид сургалтын байгууллага гэх/, нөгөө талаас ..... овогтой ..... /цаашид суралцагч гэх/ нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-т заасан хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтад (цаашид цогц сургалт гэх) хамруулах, хамрагдах талаар дараах зүйлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээ нь сургалтын байгууллага суралцагчийг ..... мэргэжлийн чиглэлээр сургахтай холбогдож үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Цогц сургалт нь суралцагчид дээрх мэргэжлийн мэргэшлийн 2 дугаар түвшний чадамжийн бүх нэгжийг эзэмшүүлэх, суралцагчийн хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дээшлүүлэх, улмаар суралцагчийн тогтвортой ажил эрхлэх боломж, чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

1.3. Дээрх зорилгоо биелүүлэхийн төлөө сургалтын байгууллага болон суралцагч нь харилцан хичээн зүтгэж, хамтран ажиллана.

1.4. Сургалт нь 20... оны ....-р сарын ....-ны өдрөөс 20... оны ....-р сарын ....-ны өдрийг дуустал нийт ..... долоо хоног үргэлжилнэ. Сургалт нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

№	Сургалтын чиглэл	Хугацаа
А	Хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын сургалт	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... хоног
Б.1	Мэргэжлийн сургалт	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... долоо хоног
Б.2	Ажлын байран дээрх дадлага	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... долоо хоног
В	Компьютер, цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... хоног
Г	Хувь хүний санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... хоног
Д	Ажил хайх чадварыг дээшлүүлэх сургалт	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... хоног

Е	Төгсөгчийн чадамж, ур чадварыг үнэлэх хөндлөнгийн үнэлгээ	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... долоо хоног/хоног
Ё	Сургалтын дараах дэмжих үйлчилгээ	20.....оны .....-р сарын ..... -ны өдрөөс 20.....оны .....-р сарын ..... -ны өдөр дуустал Нийт ..... долоо хоног

1.5. Ажлын байран дээр дадлагажуулах аж ахуйн нэгжийг сургалтын байгууллагаас санал болгосны үндсэн дээр аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хянаж, зөвшөөрнө.

1.6. Мэргэжлийн сургалт болон модульт сургалтад хамрагдах, ажлын байран дээр дадлагажих хугацаанд суралцагчид олгох хоол, унааны зардлын хөнгөлөлт олгоно. Хөнгөлөлтийг суралцагчийн ирцтэй уялдуулан, сар бүрийн сүүлчийн өдрөөр тасалбар болгон тооцож олгоно.

1.7. Нэг суралцагчид ногдох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээ сургалтын нэг өдөрт ..... төгрөг байна.

1.8. Хоол унааны хөнгөлөлтийг суралцагчийн ..... банкин дахь ..... тоот дансанд шилжүүлнэ. Хоол унааны хөнгөлөлтийг сар бүр суралцагчийн дансанд шилжүүлэхтэй холбогдсон банк хоорондын шилжүүлгийн суутгалыг суралцагч хариуцна.

Хоёр. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

2.1. Сургалтын байгууллага дараах эрхтэй:

2.1.1. Суралцагчаас сургалт, ажлын байран дээрх дадлагыг таслахгүй ирж суралцах, сургалтын байгууллагын дүрэм, дотоод журмыг хүндэтгэн мөрдөхийг шаардах,

2.1.2. Суралцагчийн ирцийг бүртгэж, ирцтэй нь уялдуулан хоол, унааны зардлыг тооцож олгох,

2.1.3. Мэргэжлийн сургалтын танхимын сургалтын дадлагын үед болон ажлын байран дээрх дадлагын үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа мөрдөхийг шаардах,

2.1.4. Суралцагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэргэжлийн сургалт, модульт сургалт, ажлын байран дээрх дадлагыг нийт 2 долоо хоногоос дээш хугацаагаар тасалсан бол сургалтаас хасах.

2.2. Сургалтын байгууллага дараах үүрэгтэй:

2.2.1. Сургалтыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, сургалтын үр дүнг хангахын төлөө чармайж ажиллах,

2.2.2. Суралцагчийн суралцах явц, хичээл зүтгэлийг идэвхтэй дэмжих,

2.2.3. Мэргэжлийн сургалтын үеийн дадлага болон ажлын байран дээрх дадлагын үед суралцагчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар тасралтгүй хангах,

2.2.4. Суралцагчид олгох хоол, унааны зардлын хөнгөлөлтийг суралцагчийн ирцтэй нь уялдуулан тооцож олгох,

2.2.5. Төгсөгчийг сургалтын дараах 3 сарын турш мэдээлэл, зөвлөгөөгөөр хангаж, дэмжиж ажиллах.

Гурав. Суралцагчийн эрх, үүрэг

3.1. Суралцагч дараах эрхтэй:

3.1.1. Сургалтын чанар, зохион байгуулалттай холбоотой санал бодлоо илэрхийлэх,

3.1.2. Сургалтын талаарх санал, гомдлоо сургалтын байгууллагад болон\эсвэл харьяа нийслэл[64], дүүрэг, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бичгээр мэдэгдэх,

3.1.3. Сургалтад бүрэн суусан өдөр бүрийн хувьд хоол, унааны зардлын хөнгөлөлт авах,

3.1.4. Сургалтын дараах 3 сарын хугацаанд холбогдох мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангагдах.

3.2. Суралцагч дараах үүрэгтэй:

3.2.1. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд заасан мэдлэг, чадамж, чадварыг бүрэн эзэмшихийн төлөө чармайж суралцах,

3.2.2. Сургалтын байгууллагын дотоод журмыг хүндэтгэн мөрдөх, сургалтын байгууллагын багш, ажилтнуудтай зөв, боловсон харьцах, хамтарч ажиллах,

3.2.3. Хамтран суралцагчидтайгаа зөв боловсон, хүндэтгэлтэй харьцах, багаар ажиллах, бие биенээ дэмжих чадавхид суралцах,

3.2.4. Сургалт, дадлагын цагаас хоцрохгүй ирэх, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалтаас завсардахгүй байх, сургалтаа төгсөх,

3.2.5. Мэргэжлийн сургалтын үеийн дадлага болон ажлын байран дээрх дадлагын үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг дагаж мөрдөх,

3.2.6. Хүндэтгэх шалтгаанаар суралцах боломжгүй болсон, эмнэлэгт хэвтсэн, эсвэл ажлын 3 хоногоос дээш хугацаагаар өвчний болон бусад шалтгаанаар чөлөө авах шаардлага гарсан бол энэ тухайгаа сургалтын байгууллагад бичгээр эсвэл цахим шуудангаар заавал мэдэгдэх, шаардлагатай бол холбогдох шийдвэр гаргуулах[65],

3.2.7. Төгсөлтийн хөндлөнгийн үнэлгээнд хамрагдаж, мэргэжлийн чадамж, ур чадвараа үнэлүүлэх,

3.2.8. Төгсөлтийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрийн зохих хэсэг бүюу 10,000 төгрөгийг[66] өөрөө хариуцаж төлөх.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Суралцагч сургалтаас завсардсан, мэргэжлийн сургалт ба ажлын байран дээрх далдлагыг нийт 2 долоо хоног буюу ажлын 10 өдрөөс дээш хугацаагаар тасалсан бол сургалтын байгууллага санаачилгаараа энэхүү гэрээг цуцална.

4.2. Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах ба хувь тус бүр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан

Иргэн:	**Сургалтын байгууллагыг төлөөлж:**
Овог	.....
Нэр	
РД:	байгууллагын /захирал, менежер/
Хаяг: ..... аймаг/дүүргийн	
....–р сум/хорооны	..... /гарын үсэг, тамга/
.....	
Утас 1: .	Хаяг:
Утас 2:	.....аймаг\дүүргийн.
Цахим хаяг:	.....–р сум/хорооны .....
Яаралтай тохиолдолд холбоо барих хүний	.....
утас:	Цахим хаяг: .....
Цахим хаяг...../гарын үсэг/	Утас: .....

Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын
сайдын 2019 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн 135 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

Суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажиллах тухай гурван талт гэрээ[67]-ний загвар

20.... оны ..... сарын .....-ны өдөр № ... . аймаг/дүүрэг

Нэг талаас нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (цаашид "ХЭБ" гэх), нөгөө талаас ..... аж ахуйн нэгж (цаашид "дадлагажуулагч" гэх), гуравдагч талаас ..... мэргэжлийн сургалтын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 27.-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-т заасан хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын хүрээнд суралцагч/дыг (цаашид "Суралцагч" гэх) ажлын байран дээр дадлагажуулахад хамтран ажиллахаар тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтаар суралцагчид тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэргэшлийн II түвшний чадамжийн бүх нэгжийг багцаар нь эзэмшүүлэх, суралцагчийн хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дээшлүүлэх, улмаар суралцагчийн тогтвортой ажил эрхлэх боломж, чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

1.2. Ажлын байран дээрх дадлага нь хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын салшгүй хэсэг мөн.

1.3. Ажлын байран дээрх дадлага (цаашид дадлага гэх) нь суралцагчийн тодорхой ажил, үйлчилгээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлыг дээшлүүлэх, ажлын бодит орчин, ажлын байрны шаардлагад дасан зохицоход нь туслах, ажил олгогч болон ажлын хамт олонтой харилцах, хамтран ажиллах зөв хандлагыг төлөвшүүлэх зорилготой байна.

1.4. Энэхүү гэрээнд хавсаргасан суралцагчдын нэрсийн жагсаалт нь гэрээний салшгүй хэсэг болно. Уг жагсаалтад суралцагч бүрийн хувьд анхаарч сайжруулбал зохих чадамжийн нэр, тэдгээрийн гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлт, гүйцэтгэлийн тухайн үеийн болон дадлагажилтийн төгсгөлөөр зорьж буй түвшин зэргийг сургалтын байгууллага ба аж ахуйн нэгж хэлэлцэн тохирч тусгасан байна. Энэ нь гурван талт гэрээний биелэлтийг дүгнэх гол арга хэрэгсэл болно. Ажлын байран дээрх дадлагаар тухайн мэргэшлийн 2 дугаар түвшний багц чадамжийн 50-иас доошгүй хувийн чадамжийг сайжруулна.

1.5. Дадлагын хугацаа ..... долоо хоног байна. Дадлагыг 20... оны .... сарын ..... -ны өдрөөс 20.... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл зохион байгуулна.

1.6. Дадлага зохион байгуулахад амжилттай хамтран ажилласан аж ахуйн нэгжид олгох урамшууллын нэг суралцагчид нэг долоо хоногт ногдох жишиг хэмжээ..... төгрөг байна.

1.7. Аж ахуйн нэгжид олгох урамшууллыг дадлагын үр дүнгийн биелэлтийг харгалзаж олгоно. Суралцагч бүрийн тухайд сайжруулбал зохих чадамжийн биелэлт нийт суралцагчдын дунджаар 70 хувиас доошгүй бол аж ахуйн нэгжид олгох урамшууллыг бүтэн олгоно. Харин үр дүнгийн биелэлт 60-69 хувьтай бол аж

[67] Нийслэлийн төвийн 6 дүүрт сургалт зохион байгуулахад энэ гэрээг байгуулна.

ахуйн нэгжид олгох урамшууллыг 10 хувиар, 50-59 хувьтай бол урамшууллыг 20 хувиар, 40-49 хувьтай бол урамшууллыг 30 хувиар гэх мэтээр хасч олгоно.

1.8. Суралцагч бүрийн хувьд тодорхойлсон чадамжийн ахиц дэвшлийг талууд хамтран дүгнэнэ.

1.9. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хичээнгүйлэн чармайх бөгөөд аль нэг тал гэрээг зөрчвөл харилцан бие биедээ шаардлага тавих эрхтэй.

Хоёр. Дадлагажуулагчийн эрх, үүрэг

2.1. Дадлагажуулагч дараах эрхтэй:

2.1.1. Ажлын байран дээрх дадлагыг зохион байгуулахад үр дүнтэй хамтран ажилласны төлөө суралцагч нэг бүрээр тооцсон урамшуулал авах,

2.1.2. Дадлагын дараа суралцагчийг ажлын байраар хангах үүрэг хүлээхгүй (хүсвэл ажлын байраар хангах эрх нь нээлттэй),

2.1.3. Дадлагын үр нөлөөг сайжруулах асуудлаар сургалтын байгууллагатай зөвлөлдөх, шаардлагатай дэмжлэг хүсэх,

2.1.4. Хамтран ажиллаж буй сургалтын байгууллагатай холбогдуулан санал бодлоо илэрхийлэх, гомдол гаргах.

2.2. Дадлагажуулагч дараах үүрэгтэй:

2.2.1. Сургалтын байгууллагатай хамтран суралцагч бүрийн хувьд сайжруулбал зохих чадамжийн нэгжүүдийг тодорхойлж, дадлагын үр нөлөөг хангаж ажиллах,

2.2.2. Суралцагч/дын дадлагыг удирдах, хянах, заавар, зөвлөгөө өгөх байгууллагын зохих мэргэжилтэй ажилтан/уудыг томилж, суралцагч/дын чадамжийг бодитой дээшлүүлэхэд анхаарах, дадлагын багшийг тухайлан томилж, зохих хэмжээний урамшуулал олгох албан ёсны шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх

2.2.3. Суралцагчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар тасралтгүй хангаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдүүлэх,

2.2.4. Суралцагчийн нэг өдрийн ажлын цагийн урт 8 цагаас ихгүй, өдрийн амралтын цагийг 1 цагаас хэтрүүлэхгүй байх,

2.2.5. Суралцагчийг шөнийн цагаар болон илүү цагаар ажиллуулахгүй байх,

2.2.6. Суралцагчдын ирцийн бүртгэлийг өдөр тутам, үнэн зөв хөтлөх, дадлага тасалж буй суралцагчийн талаар сургалтын байгууллагад цаг тухайд нь мэдээлэх,

2.2.7. Сургалтын байгууллагатай хамтарч дадлагын зорилт, үр дүнг хэлэлцэж тохирох, дүгнэх.

Гурав. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

3.1. Сургалтын байгууллага дараах эрхтэй:

3.1.1. Аж ахуйн нэгж дээр очиж дадлагын явцтай танилцах, дадлагын үр нөлөөг дээшлүүлэх талаар аж ахуйн нэгжтэй зөвлөлдөх, шаардлагатай зөвлөгөө өгөх, шаардлага тавих,

3.1.2. Аж ахуйн нэгжээс суралцагчдын ирцийн бүртгэлийг сар бүрийн дунд, сарын эцсийн өдрөөр тасалбар болгон албажуулан гаргуулж авах,

3.1.3. Аж ахуйн нэгжтэй хамтарч дадлагын зорилт, үр дүнг хэлэлцэж тохирох, дүгнэх.

3.2. Сургалтын байгууллага дараах үүрэгтэй:

3.2.1. Суралцагч бүрийн хувьд анхаарч сайжруулбал зохих чадамжийн нэгжүүдийг дадлагажуулагч болон суралцагчтай хамтарч тодорхойлох,

3.2.2. Сургалтын байгууллагын багш хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж дээр тодорхой хугацаарийн дагуу очиж, суралцагч болон аж ахуйн нэгжид шаардлагатай зөвлөгөө өгөх, мэдлэг, туршлагаа хуваалцах,

3.2.3. Суралцагчдын ирцэд хяналт тавих, суралцагчийн эрмэлзэл, идэвхийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах,

3.2.4. Хэрэв суралцагч цогц сургалтын бүхий л арга хэмжээнд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийт 2 долоо хоног буюу ажлын 10 хоногийн хугацаанд хамрагдаагүй тохиолдолд уг суралцагчийг сургалтаас хасах тухай шийдвэр гаргаж, харьяа аймаг, нийслэл, алслагдсан 3 дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдэгдэх.

3.2.5. Ажлын байран дээрх дадлагажуулалтын үр дүнг аж ахуйн нэгжтэй хамтран дүгнэж, харьяа аймаг, нийслэл, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад тайлагнах.

Дөрөв. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх, үүрэг

4.1. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дараах эрхтэй:

4.1.1. Дадлагын ажилд хөндлөнгийн хяналт тавих, дадлагын ажлын үр нөлөөг сайжруулах чиглэлээр сургалтын байгууллага болон аж ахуйн нэгжид зөвлөгөө өгөх, шаардлага тавих,

4.1.2. Мэргэжлийн сургалтын байгууллагаас ажлын байрны дадлагатай холбоотой тайлан, мэдээ гаргуулж авах,

4.1.3. Аж ахуйн нэгжид олгох урамшууллыг олгохдоо гурван талт гэрээний биелэлтийг харгалзаж тооцох,

4.1.4. Суралцагч ажлын байран дээрх дадлагаас завсардсан бол тухайн суралцагчийн завсардсан хугацаанд ногдох урамшууллыг хасч тооцох,

4.1.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа дадлагажуулагчид сануулга өгөх, гэрээг дуусгавар болгох, сургалтын байгууллагын санал болгосон жагсаалтаас шаардлага хангасан дараагийн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээг байгуулах.

4.2. Хөдөлмөр, эрхлэлтийн байгууллага дараах үүрэгтэй:

4.2.1. Сургалтын байгууллага болон аж ахуйн нэгж хамтран дадлагажуулалтын үр дүнг дүгнэхэд оролцох, хөндлөнгийн хяналт тавих,

4.2.2. Энэхүү гурван талт гэрээний биелэлтийг дүгнэсний үндсэн дээр аж ахуйн нэгжийн урамшууллыг сургалтын байгууллагын явцын тайлан 2-ыг хүлээж авснаас хойш ажлын 15 хоногийн дотор аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлэх.

Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээ нь 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс 20 ... оны ... сарын ... -ны өдөр хүртэл хүчинтэй байна.

5.2. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Шийдвэрлэх боломжгүй маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.3. Энэхүү гэрээг талууд гурван хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

Аж ахуйн нэгжийг төлөөлж:	**Сургалтын байгууллагыг төлөөлж:**	.....
..... Аж ахуйн нэгжийн захирал, менежер	.....	**Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж:**
.....	Сургалтын байгууллагын захирал, менежер	Газар, хэлтсийн дарга
/гарын үсэг, тамга/	.....	.....
Хаяг:	/гарын үсэг, тамга/	/гарын үсэг, тамга/
Утас:	Хаяг:.....	Албан тушаал:.....
Цахим хаяг:	Утас:	Хаяг: .....
	Цахим хаяг:	Утас: .....
		Цахим хаяг: .....

Ажлын байран дээрх дадлагын үр дүнг төлөвлөх, дүгнэх хуудас

Аж ахуйн нэгжийн нэр:.....

Сургалтын байгууллагын нэр:.....

Дадлагажуулалтын хугацаа:.....

Дд	Суралцагчийн овог нэр, регистрийн дугаар	Суралцагчийн сайжруулбал зохих чадамжийн нэр	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дадлага эхлэх үеийн түвшин	Дадлага дууссан үеийн түвшин	Биелэл-тийн хувь
1						
		Биелэлтийн дундаж				
2						
		Биелэлтийн дундаж				
3						
		Биелэлтийн дундаж				
4						
		Биелэлтийн дундаж				
5						
		Биелэлтийн дундаж				
	Биелэлтийн нийт дундаж					

Үр дүнг төлөвлөсөн		Үр дүнг дүгнэсэн	
Аж ахуйн нэгжийг төлөөлж: Нэр: Албан тушаал:	Гарын үсэг:	Аж ахуйн нэгжийг төлөөлж: Нэр: Албан тушаал:	Гарын үсэг:
Сургалтын байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:		Сургалтын байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:	
Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:		Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:	
Суралцагч: Нэр		Суралцагч: Нэр	
Огноо:		Огноо:	

Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах, суралцагчийг ажлын байран дээр дадлагажуулах, ажлын байраар хангахад хамтран ажиллах тухай гурван талт гэрээ[68]-ний загвар

20.... оны ..... сарын .....-ны өдөр № .... аймаг/дүүрэг

Нэг талаас ..... аймаг, нийслэлийн алслагдсан дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (цаашид "ХЭБ" гэх), нөгөө талаас ..... аж ахуйн нэгж , гуравдагч талаас ..... мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага (цаашид "сургалтын байгууллага" гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-т заасан хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын хүрээнд хамтран ажиллах, суралцагч/дыг (цаашид "Суралцагч" гэх) ажлын байран дээр дадлагажуулах, ажлын байраар хангах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтаар суралцагчид тодорхой ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах мэргэшлийн II түвшний чадамжийн бүх нэгжийг багцаар нь эзэмшүүлэх, суралцагчийн хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дээшлүүлэх, улмаар суралцагчийн ажлын байран дээр дадлагажуулан, тогтвортой ажлын байраар хангаж, хөдөлмөр эрхлэх боломж, чадварыг нэмэгдүүлэх зорилготой.

1.2. Аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтыг ажлын байрны бодит эрэлт дээр тулгуурлан зохион байгуулна. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нягт хамтран ажиллана. Амжилттай төгсөгчдийг ажлын байраар хангана.

1.3. Ажлын байран дээрх дадлага нь хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын салшгүй хэсэг мөн.

1.4. Ажлын байран дээрх дадлага (цаашид дадлага гэх) нь суралцагчийн тодорхой ажил, үйлчилгээ гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлыг дээшлүүлэх, ажлын бодит орчин, ажлын байрны шаардлагад дасан зохицоход нь туслах, ажил олгогч болон ажлын хамт олонтой харилцах, хамтран ажиллах зөв хандлагыг төлөвшүүлэх зорилготой байна.

1.5. Энэхүү гэрээнд хавсаргасан суралцагчдын нэрсийн жагсаалт нь гэрээний салшгүй хэсэг болно. Уг жагсаалтад суралцагч бүрийн хувьд анхаарч сайжруулбал зохих чадамжийн нэр, тэдгээрийн гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлт, гүйцэтгэлийн тухайн үеийн болон дадлагажилтийн төгсгөлөөр зорьж буй түвшин зэргийг сургалтын байгууллага ба аж ахуйн нэгж хэлэлцэн тохирч тусгасан байна. Энэ нь гурван талт гэрээний биелэлтийг дүгнэх гол арга хэрэгсэл болно. Ажлын байран дээрх дадлагаар тухайн мэргэшлийн 2 дугаар түвшний багц чадамжийн 50-иас доошгүй хувийн чадамжийг сайжруулна.

1.6. Дадлагын хугацаа ..... долоо хоног байна. Дадлагыг 20... оны .... сарын ..... -ны өдрөөс 20.... оны ..... сарын .....-ны өдөр хүртэл зохион байгуулна.

1.7. Дадлага зохион байгуулахад амжилттай хамтран ажилласан ажил олгогчид олгох урамшууллын нэг суралцагчид нэг долоо хоногт ногдох жишиг хэмжээ..... төгрөг байна.

---

[68] Аймаг, алслагдсан 3 дүүрэгт сургалт зохион байгуулахад энэ гэрээг байгуулна.

1.8. Аж ахуйн нэгжид олгох урамшууллыг дадлагын үр дүнгийн биелэлтийг харгалзаж олгоно. Суралцагч бүрийн тухайд сайжруулбал зохих чадамжийн биелэлт нийт суралцагчдын дунджаар 70 хувиас доошгүй бол аж ахуйн нэгжид олгох урамшууллыг бүтэн олгоно. Харин үр дүнгийн биелэлт 60-69 хувьтай бол аж ахуйн нэгжид олгох урамшууллыг 10 хувиар, 50-59 хувьтай бол урамшууллыг 20 хувиар, 40-49 хувьтай бол урамшууллыг 30 хувиар гэх мэтээр хасч олгоно.

1.9. Суралцагч бүрийн хувьд тодорхойлсон чадамжийн ахиц дэвшлийг талууд хамтран дүгнэнэ.

1.10. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг хичээнгүйлэн чармайх бөгөөд аль нэг тал гэрээг зөрчвөл харилцан бие биедээ шаардлага тавих эрхтэй.

Хоёр. Ахуйн нэгжийн эрх, үүрэг

2.1. Аж ахуйн нэгж дараах эрхтэй:

2.1.1. Тухайн орон нутагт зохион байгуулах сургалтын санал, хөтөлбөр боловсруулахад орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагатай хамтран ажиллаж, тухайн үйлдвэрлэлийн технологитой холбоотой ажлын байран дээр шаардагдах ур чадвар, ажилбарыг сургалтын хөтөлбөрт тусгуулах, сургалтын явцад хяналт, шаардлага тавих, дэмжлэг туслалцаа үзүүлэх

2.1.2. Суралцагчдыг сонгоход оролцох ,

2.1.3. Ажлын байран дээрх дадлага зохион байгуулахад үр дүнтэй хамтран ажилласны төлөө суралцагч нэг бүрээр тооцсон урамшуулал авах,

2.1.4. Дадлагын үр нөлөөг сайжруулах асуудлаар сургалтын байгууллагатай зөвлөлдөх, шаардлагатай дэмжлэг хүсэх,

2.1.5. Хамтран ажиллаж буй сургалтын байгууллагатай холбогдуулан санал бодлоо илэрхийлэх, гомдол гаргах.

2.2. Аж ахуйн нэгж дараах үүрэгтэй:

2.2.1. Амжилттай төгсөгчдийг ажлын байраар хангах баталгааг сургалт эхлэхээс өмнө, бичгээр үйлдэн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүргүүлж, сургалтын дараа бүрэн хэрэгжүүлэх,

2.2.2. Тухайн чиглэлийн сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцож, сургалтын байгууллагатай хамтран ажиллах,

2.2.3. Тухайн мэргэжлийн чиглэлээр суралцаж, ажлын байртай болох хүсэлтээ гаргасан иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай хамтран үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцаа танилцуулах, ярилцлага хийх зэргээрсурах сонирхлыг нь дэмжих, сургалтад хамрагдах иргэдийг сонгоход оролцох,

2.2.4. Сургалтын байгууллагатай хамтран суралцагч бүрийн хувьд сайжруулбал зохих чадамжийн нэгжүүдийг тодорхойлж, дадлагын үр нөлөөг хангаж ажиллах,

2.2.5. Суралцагч/дын дадлагыг удирдах, хянах, заавар, зөвлөгөө өгөх байгууллагын зохих мэргэжилтэй ажилтан/уудыг томилж, суралцагч/дын чадамжийг бодитой дээшлүүлэхэд анхаарах, дадлагын багшийг тухайлан томилж, зохих хэмжээний урамшуулал олгох албан ёсны шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх,

2.2.6. Суралцагчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар тасралтгүй хангаж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдүүлэх,

2.2.7. Суралцагчийн нэг өдрийн ажлын цагийн урт 8 цагаас ихгүй, өдрийн амралтын цагийг 1 цагаас хэтрүүлэхгүй байх,

2.2.8. Суралцагчийг шөнийн цагаар болон илүү цагаар ажиллуулахгүй байх,

2.2.9. Суралцагчдын ирцийн бүртгэлийг өдөр тутам, үнэн зөв хөтлөх, дадлага тасалж буй суралцагчийн талаар сургалтын байгууллагад цаг тухайд нь мэдээлэх,

2.2.10. Сургалтын байгууллагатай хамтарч сургалтын болон дадлагын зорилт, үр дүнг хэлэлцэж тохирох, дүгнэх.

Гурав. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

3.1. Сургалтын байгууллага дараах эрхтэй:

3.1.1. Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон аж ахуйн нэгжтэй хамтран ажлын байрны бодит эрэлтэд тулгуурласан хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах санал, сургалтын хөтөлбөр боловсруулах,

3.1.2. Аж ахуйн нэгж дээр очиж дадлагын явцтай танилцах, дадлагын үр нөлөөг дээшлүүлэх талаар аж ахуйн нэгжтэй зөвлөлдөх, шаардлагатай зөвлөгөө өгөх, шаардлага тавих,

3.1.2. Аж ахуйн нэгжээс суралцагчдын ирцийн бүртгэлийг сар бүрийн дунд, сарын эцсийн өдрөөр тасалбар болгон албажуулан гаргуулж авах,

3.1.3. Аж ахуйн нэгжтэй хамтарч сургалтын хөтөлбөр боловсруулах, дадлагын зорилт, үр дүнг хэлэлцэж тохирох, дүгнэх.

3.2. Сургалтын байгууллага дараах үүрэгтэй:

3.2.1. Суралцагч бүрийн хувьд анхаарч сайжруулбал зохих чадамжийн нэгжүүдийг аж ахуйн нэгж болон суралцагчтай хамтарч тодорхойлох,

3.2.2. Сургалтын байгууллагын багш хамтран ажиллаж буй аж ахуйн нэгж дээр тодорхой хугацаанд дагуу очиж, суралцагч болон аж ахуйн нэгжид шаардлагатай зөвлөгөө өгөх, мэдлэг, туршлагаа хуваалцах,

3.2.3. Суралцагчдын ирцэд хяналт тавих, суралцагчийн эрмэлзэл, идэвхийг дээшлүүлэхэд анхаарч ажиллах,

3.2.4. Хэрэв суралцагч цогц сургалтын бүхий л арга хэмжээнд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийт 2 долоо хоног буюу ажлын 10 хоногийн хугацаанд хамрагдаагүй тохиолдолд уг суралцагчийг сургалтаас хасах тухай шийдвэр гаргаж, харьяа аймаг, алслагдсан 3 дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдэгдэх.

3.2.5. Ажлын байран дээрх дадлагажуулалтын үр дүнг ажил олгогчтой хамтран дүгнэж, харьяа аймаг, алслагдсан гурван дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад тайлагнах.

3.2.6. Танхимын сургалт, ажлын байран дээрх дадлагаа амжилттай дуусгаж, хөндлөнгийн үнэлгээнд хамрагдан чадамжийн гэрчилгээ авсан төгсөгчдийг ажил олгогчид хүлээлгэн өгөх,

Дөрөв. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх, үүрэг

4.1. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дараах эрхтэй:

4.1.1. Танхимын сургалт болон дадлагын ажилд хөндлөнгийн хяналт тавих, сургалт, дадлагын ажлын үр нөлөөг сайжруулах чиглэлээр сургалтын байгууллага болон аж ахуйн нэгжид зөвлөгөө өгөх, шаардлага тавих,

4.1.2. Мэргэжлийн сургалтын байгууллагаас ажлын байрны дадлагатай холбоотой тайлан, мэдээ гаргуулж авах,

4.1.3. Гурван талт гэрээний биелэлтийг үндэслэн аж ахуйн нэгжид олгох урамшууллыг тооцох,

4.1.4. Суралцагч ажлын байран дээрх дадлагаас завсардсан бол тухайн суралцагчийн завсардсан хугацаанд ногдох урамшууллыг хасч тооцох,

4.1.5. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа аж ахуйн нэгжид сануулга өгөх, гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах, дэмжлэг үзүүлэх

4.2. Хөдөлмөр, эрхлэлтийн байгууллага дараах үүрэгтэй:

4.2.1. Сургалтын байгууллага болон ажил олгогч хамтран сургалт, дадлагажуулалтын үр дүнг дүгнэхэд оролцох, хөндлөнгийн хяналт тавих,

4.2.2. Энэхүү гурван талт гэрээний биелэлтийг дүгнэсний үндсэн дээр аж ахуйн нэгжийн урамшууллыг сургалтын байгууллагын явцын тайлан 2-ыг хүлээж авснаас хойш ажлын 15 хоногийн дотор аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлэх.

Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээ нь 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс 20 ... оны ... сарын ... -ны өдөр хүртэл хүчинтэй байна.

5.2. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Шийдвэрлэх боломжгүй маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.3. Энэхүү гэрээг талууд гурван хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

Аж ахуйн нэгжийг төлөөлж:	**Сургалтын байгууллагыг төлөөлж:**	.....
..... Аж ахуйн нэгжийн захирал, менежер	..... Сургалтын байгууллагын захирал, менежер	**Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж:** Газар, хэлтсийн дарга
.....	.....	.....
/гарын үсэг, тамга/	/гарын үсэг, тамга/	/гарын үсэг, тамга/
Хаяг:	Хаяг:.....	Албан тушаал:.....
Утас:	Утас:	Хаяг: .....
Цахим хаяг:	Цахим хаяг:	Утас: .....
		Цахим хаяг: .....

Ажлын байран дээрх дадлагын үр дүнг төлөвлөх, дүгнэх хуудас

Аж ахуйн нэгжийн нэр:.....

Сургалтын байгууллагын нэр:.....

Дадлагажуулалтын хугацаа:.....

Дд	Суралцагчийн овог нэр, регистрийн дугаар	Суралцагчийн сайжруулбал зохих чадамжийн нэр	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дадлага эхлэх үеийн түвшин	Дадлага дууссан үеийн түвшин	Биелэлтийн хувь
1						
		Биелэлтийн дундаж				
2						
		Биелэлтийн дундаж				
3						
		Биелэлтийн дундаж				
4						
		Биелэлтийн дундаж				
5						
		Биелэлтийн дундаж				
	Биелэлтийн нийт дундаж					

Үр дүнг төлөвлөсөн		**Үр дүнг дүгнэсэн**	
Аж ахуйн нэгжийг төлөөлж: Нэр: Албан тушаал:	Гарын үсэг:	Аж ахуйн нэгжийг төлөөлж: Нэр: Албан тушаал:	Гарын үсэг:
Сургалтын байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:		Сургалтын байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:	
Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:		Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж: Нэр: Албан тушаал:	
Суралцагч: Нэр		Суралцагч: Нэр	
Огноо:		Огноо:	

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 01. дүгээр сарын 26.-ны өдрийн 4/35 дугаар тушаалын тавдугаар хавсралт

1. Нийслэлд зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын мэргэжлийн сургалтын чиглэл, хугацаа, нэг суралцагчид ногдох зардлын дээд хэмжээ

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Мэргэжлийн чиглэл	Мэргэжлийн сургалтын хугацаа	Ажлын байран дээрх дадлагын хугацаа	Нийт хугацаа	Мэргэжлийн сургалтын нэг суралцагчид ногдох зардлын дээд хэмжээ	
		Долоо хоногоор (ажлын 5 өдрөөр тооцсон)			Ажлын 5 өдөрт ногдох зардлын дээд хэмжээ	Зардлын нийт дээд хэмжээ
1. Барилга болон техникийн үйлчилгээ	1.Барилгын цахилгаанчин	8	7	15	52,000	416,000
	2.Барилгын засал чимэглэлчин	7	7	14	52,000	364,000
2.Боловсруулах үйлдвэр	3.Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	9	8	17	39,000	351,000
	4.Мах боловсруулах үйлдвэрлэлийн тан	8	7	15	40,000.00	317,000
	5. Сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан	7	7	14	39,000	273,000
	6. Арьс, шир боловсруулалтын технологийн ажилтан	7	7	14	39,000	273,000
	7. Эсгий, ноос ноолуур боловсруулах анхан шатны технологийн ажилтан	9	8	17	39,000	351,000
3. Бөөний болон жижиглэн худалдаа, ахуйн болон засвар үйлчилгээ	8.Зочид буудлын өрөөний үйлчлэгч	8	7	15	30,290	242,320

2. Аймаг, нийслэлийн алслагдсан 3 дүүрэгт зохион байгуулах хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын мэргэжлийн сургалтын ерөнхий чиглэл, нэг суралцагчид ногдох зардлын жишиг хэмжээ

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	Мэргэжлийн сургалтын ерөнхий чиглэл	5 ажлын өдөрт ногдох нэг суралцагчийн зардлын хэмжээ /төгрөг/
А. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур	1. Үр тариа, тэжээлийн ургамал тариалах	35,000
	2. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах	35,000
	3. Ойн аж ахуй, мод бэлтгэх	35,000
Б.Уул уурхай, олборлолт	1. Машин механизм, төхөөрөмжийн оператор	60,000
	2. Машин механизм, төхөөрөмжийн засварчин	52,000
	3. Зүтгүүрийн машинч /төмөр замын ажилтан/	52,000
	4. Цооног өрөмдөгч, адилтгах бусад ажилтан	48,000
	5. Далд ба ил уурхайчин	48,000
	6. Баяжуулагч	43,000
	7. Зам, засвар үйлчилгээний ажилтан	48,000
В.Боловсруулах үйлдвэр	1. Хөнгөн үйлдвэрлэлийн оёдол, эсгүүр	39,000
	2. Хөнгөн үйлдвэрлэлийн сүлжигч, нэхэгч, кительчин	39,000
	3. Арьс, шир боловсруулалтын анхан шатны технологи	39,000
	4. Гутал үйлдвэрлэлийн технологи	39,000
	5. Модон эдлэл буюу мужаан	39,000
	6. Хүнсний боловсруулах үйлдвэрлэл /мах, сүү/	39,000
	7. Хоол үйлдвэрлэл, тогооч	39,000
	8. Талх, нарийн боов	30,000
Г.Барилга болон техникийн үйлчилгээ	1. Кран өргөгч цамхаг түүнтэй адилтгах машины оператор	48,000
	2. Засал чимэглэл	52,000
	3. Өрөг угсрагч	52,000
	4. Бетон арматур	56,000
	5. Цахилгаанчин	52,000
	6. Гагнуурчин	52,000
	7. Сантехникч	52,000
	8. Барилгын мужаан	52,000
	9. Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн оператор	52,000
	10. Шилчин	43,000
	11. Дээвэрчин	43,000
	12. Металл хийц бэлтгэгч, нимгэн төмөрчин	52,000
	13. Цахилгаан төхөөрөмжийн механикч /тохируулагч/	52,000
	14. Агааржуулалт, агаар сэлгэлтийн механик	48,000
	15. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	43,000
	16. Хөдөө аж ахуйн машин механизм, тоног төхөөрөмжийн механикч, засварчин	52,000
	17. Барилгын материал үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн засварчин	48,000
Д.Бөөний болон жижиглэн худалдаа, ахуйн болон засвар үйлчилгээ	1. Автомашины засвар	35,000
	2. Гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар	35,000
	3. Телевиз, гар утасны засварчин	30,000
	4. Жижиг эдлэлийн засварчин	26,000
	5. Зочид буудлын үйлчлэгч, үйлчилгээний ажилтан	30,000
	6. Цэцэрлэгийн багшийн туслах ажилтан	30,000
	7. Аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч	30,000

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн 85 дугаар тушаалын
зургаадугаар хавсралт

Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын бусад зардлын жишиг хэмжээ

1. Модульт сургалтын нэг суралцагчид ногдох зардлын хэмжээ:

Модульт сургалтын чиглэл	Модульт сургалтын хугацаа	Модульт сургалтын нэг суралцагчид ногдох зардал	
		Нэг өдөрт ногдох	Нийт
1. Хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын сургалт	5 хоног	8,000	40,000
2. Компьютер, цахим орчинд ажиллах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалт	5 хоног	8,000	40,000
3. Хувь хүний санхүүгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт	3 хоног	8,000	24,000

2. Суралцагчид сургалтын нэг өдөрт олгох хоол, унааны зардлын хөнгөлөлтийн хэмжээ нийслэлийн 9 дүүрэгт 5,000, аймагт,4,000 төгрөг байна.

3. Сумаас аймгийн төвд ирж суралцагчийн нэг өдөрт олгох хоол, унааны зардлын хөнгөлөлтийн хэмжээ 6,000 төгрөг байна.

4. Ажлын байран дээрх дадлага зохион байгуулахад амжилттай хамтарч ажилласан аж ахуйн нэгжид олгох урамшууллын нэг суралцагчийн ажлын 5 өдрийн дадлагад ногдох хэмжээ 40,000 төгрөг байна.

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн А/365 дугаар тушаалын
долоодугаар хавсралт

Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт төгсөгчийн чадамжийн үнэлгээний төлбөрийн хэмжээ

№	Зардлын төрөл	Нэгж	Нийт зардал	Үүнээс	
				ХЭДС / ХЗЗДТХ-өөс төлөх[69]	Суралцагч төлөх
1	Төгсөгчийн чадамжийн хөндлөнгийн үнэлгээний төлбөрийн хэмжээ	1 удаа	60,000	50,000	10,000

---oOo---

[69] Хөндлөнгийн үнэлгээний болон үнэлгээний материалын зардлын дээд хэмжээ

Хөдөлмөр, нийгмийн хамгаллын
сайдын 2019 оны 57 дугаар сарын
26-ны өдрийн 130 дугаар тушаалын
наймдугаар хавсралт

Зээлийн дараах санхүүгийн бус дэмжлэгийг хариуцан гүйцэтгүүлэх тухай гэрээний загвар

..... аймаг/дүүрэг № ... 20... оны .... сарын .... өдөр

Энэхүү гэрээг ..... аймаг, дүүргийн хөдөлмөр, эрхлэлтийн байгууллага (цаашид ХЭБ гэх) болон ..... байгууллага (цаашид бизнес хөгжлийн байгууллага гэх) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-т (цаашид туршилтын хөтөлбөр гэх) заасан бичил бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг зохион байгуулахтай холбогдуулан дараах зүйлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ нь бичил бизнес эрхлэгчдийг аж ахуйн үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэх, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

1.2. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд жижиг зээл авсан иргэдийг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамруулна.

1.3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ нь бизнес хөгжлийн сургалт (аж ахуй хөгжүүлэлт, санхүүгийн бүртгэл, маркетинг, борлуулалтын чиглэлээр), бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ (бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалт, бизнес менежментийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх, менторинг үйлчилгээ үзүүлэх)-ээс бүрдэнэ.

1.4. Бизнес хөгжлийн сургалтын үргэлжлэх хугацаа нь 50 цагаас доошгүй хөтөлбөртэй байна. Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ 20-30 цаг байна. Мөн, бизнес менежментийн нэг менторт нэг сард оногдох үйлчлүүлэгчийн тоо 5-аас хэтрэхгүй байна. Ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, сайжруулалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээг бүлгээр зохион байгуулж болно. Эдгээр үйлчилгээг жижиг зээл авсан иргэнтэй гурван талт гэрээ байгуулснаас хойш 3 сарын хугацаанд багтаан хэрэгжүүлнэ.

1.5. Бизнес хөгжлийн сургалт, бизнесийн зөвлөн туслах үйлчилгээг жижиг зээл авсан иргэн бүрт, багцаар нь, хэрэгцээнд нь нийцүүлж үзүүлнэ.

1.6. Энэхүү гэрээний хугацаанд нийт ..... иргэнд[70] зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг үзүүлнэ.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх, үүрэг

2.1. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд жижиг зээл авсан бичил бизнес эрхлэгчийн дэлгэрэнгүй бүртгэлийг бизнес хөгжлийн байгууллагад сар бүрийн 15-ны өдрөөр тасалбар болгож хүргүүлнэ.

---

[70] Гэрээний хугацаанд зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх иргэдийн тоог урьдчилан тогтоох боломжгүй тул тухайн аймаг/дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас энэ тоог туршилтын хөтөлбөрийн хүрээнд тухайн орон нутагт хуваарилсан жижиг зээлийн санхүүжилтийн хэмжээ, жижиг зээл авах иргэний төлөвлөгөөт тоотой багцаалж гаргана.

2.2 Бизнес хөгжлийн байгууллага болон зээл авсан иргэнтэй хамтран зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, гурван талт гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

2.3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдаж байгаа бичил бизнес эрхлэгчийн талаарх мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

2.4. Бизнес хөгжлийн байгууллага зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг чанартай, бүрэн хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавина.

2.5. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний тайланг бизнес хөгжлийн байгууллагаас 2 сар тутам хүлээн авч, санхүүжилтийг энэхүү гэрээний дөрөвдүгээр зүйлд заасны дагуу шилжүүлнэ.

2.6. Хэрэв бизнес хөгжлийн байгууллага гэрээний санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан бол нөхөн төлүүлэх арга хэмжээ авах эрхтэй. Түүнчлэн гэрээгээр хүлээсэн үүргээ чанартай, бүрэн гүйцэд хэрэгжүүлэхгүй байгаа нь нотлогдвол гэрээг дуусгавар болгохыг санаачлах эрхтэй.

2.7. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдсан иргэн бүрээс сэтгэл ханамжийн судалгааг батлагдсан маягтын дагуу цахим хэлбэрээр авч, судалгааны дүнг бизнес хөгжлийн байгууллагын үйл ажиллагааны чанар, үр дүнг дээшлүүлэхэд ашиглана.

Гурав. Бизнес хөгжлийн байгууллагын эрх, үүрэг

3.1. Сар бүр ХЭБ-аас ирүүлэх бүртгэлд багтсан иргэдийн зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний хэрэгцээг ХЭБ-тай хамтран тодорхойлж, иргэн ба ХЭБ-тай байгуулсан гурван талт гэрээний дагуу иргэний хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг сайн төлөвлөж, үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлнэ.

3.2. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлсэн тухай мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв тэмдэглэж, үйлчилгээ авсан иргэнээр гарын үсэг зуруулж баримтжуулна.

3.3. Тодорхой шалтгааны улмаас зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнээс хасагдсан иргэдийн нэрс, үйлчилгээ авахаа зогсоосон шалтгааныг ХЭБ-д сар бүрийн сүүлчийн өдрөөр тасалбар болгон албан бичгээр мэдэгдэнэ.

3.4. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний үед жижиг зээл авсан иргэний хэрэгжүүлж буй төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг хязгаарлаж, бууруулж буй байдалд хяналт тавьж, зөвлөгөө өгөхийн зэрэгцээ хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаагаар тасралтгүй хангаж ажиллана.

3.5. Үйлчилгээнд хамрагдаж буй иргэдийн талаарх сар тутмын тоо мэдээг дараа сарын 3-ны өдрийн дотор ХЭБ-д хүргүүлнэ.

3.6. Үйл ажиллагааны тайланг, батлагдсан маягтын дагуу, гэрээ байгуулсан өдрөөс хойш 2 сар тутамд ХЭБ-д хүргүүлнэ.

3.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударга, ил тод хэрэгжүүлнэ.

3.8. Гэрээний дагуу олгох санхүүжилтийг гэрээний 4-дүгээр зүйлд заасан хугацаанд дансандаа шилжүүлэхийг ХЭБ-аас шаардах, нэхэмжлэх эрхтэй.

Дөрөв. Санхүүжилт, төлбөрийн хуваарь

4.1. Энэхүү гэрээний санхүүжилтийн нэрлэсэн дүн нь нийт ..... \.....\ хүртэл төгрөг байна.

4.2. Дээрх нэрлэсэн дүн нь гэрээний 1.6-д заасан тооны иргэнд санхүүгийн бус үйлчилгээг багцаар нь үзүүлэх зардлын дээд хэмжээ болно.

4.3. Гэрээний 1.6-д заасан хүний тоог багцаалж тооцсон, мөн санхүүгийн бус үйлчилгээг жижиг зээл авсан иргэдий хэрэгцээнд нийцүүлж үзүүлэх тул зээлдэгч бүртэй ажиллах цаг адил байхгүй тул гэрээний санхүүжилтийг багц үйлчилгээг бүрэн

авсан, 3 талт гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн зээлдэгчдийн бодит тоонд үндэслэж, баталсан зардлын жишгийг баримтлан тооцож олгоно.

4.4. ХЭБ нь бизнес хөгжлийн байгууллагаас ирүүлсэн тайланг гэрээ байгуулсан өдрөөс хойш 2 сар тутамд хүлээн авч, тайлан хүлээж авснаас хойш ажлын 10 хоногт багтаан гэрээний санхүүжилтийг шилжүүлнэ.

Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээ нь 20... оны .... сарын .... -ны өдрөөс 20...оны .... сарын ....-ны өдөр хүртэл хүчинтэй.

5.2. Гэрээний хугацаа ба гэрээний 1.6-д заасан иргэний тоонд өөрчлөлт оруулах бол талуудын аль нэг нь энэ талаарх хүсэлтээ бичгээр мэдэгдсэний үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

5.3. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Шийдвэрлэх боломжгүй маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.4. Энэхүү гэрээг талууд хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээний хувь бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан талууд

А талыг төлөөлж:	**Б талыг төлөөлж:**
.....Аймаг/ дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга	..... Байгууллагын захирал
..... /нэр/	..... /нэр/
..... /гарын үсэг, тамга/	..... /гарын үсэг, тамга/
Хаяг:	Хаяг: ....
Утас:	Утас: .....

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 04 дүгээр сарын
26-ны өдрийн 133 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх тухай гурван талт гэрээний загвар

..... аймаг/дүүрэг № ... 20.... оны .... сарын .... өдөр

Энэхүү гэрээ нь нэг талаас ..... (Бизнес хөгжлийн байгууллага гэх), нөгөө талаас ..... овогтой ..... (бичил бизнес эрхлэгч гэх/, гуравдагч талаас ..... аймаг, дүүргийн Хөдөлмөр, эрхлэлтийн байгууллага (ХЭБ) нар Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-ийг (туршилтын хөтөлбөр гэх) хэрэгжүүлэх хүрээнд жижиг зээл авсан иргэнд зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд талууд дараах зүйлийг харилцан тохиролцов.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Зээлийн дарахь санхүүгийн бус үйлчилгээ нь бичил бизнес эрхлэгчдийг аж ахуйн үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэх, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой.

1.2. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ нь бизнес хөгжлийн сургалт (аж ахуй хөгжүүлэлт, санхүүгийн бүртгэл, маркетинг, борлуулалтын чиглэлээр), бизнесийн зөвлөн туслах үйлчилгээнээс (бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалт, бизнес менежментийн чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгөх, менторинг үйлчилгээ үзүүлэх) бүрдэнэ.

1.3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг бичил бизнес эрхлэгчид энэхүү гурван талт гэрээг байгуулсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд үзүүлнэ.

1.4. Бичил бизнес эрхлэгчид үзүүлэх бизнес хөгжлийн сургалтын үргэлжлэх хугацаа ажлын 7 хоног буюу 50-иас доошгүй цагийн хөтөлбөртэй, бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ нь нийт 20-30 цагийн үйлчилгээ байна. Үүнээс, бизнес менежментийн менторинг үйлчилгээ 5 цагаас хэтрэхээргүй байна. Ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, сайжруулалтын чиглэлээр зөвлөх үйлчилгээг багавтар бүлгээр зохион байгуулж болно.

1.5. Бизнес хөгжлийн сургалтанд нэг иргэнийг нэг өдөрт хамруулах зардал 8,500 төг, бизнесийн зөвлөн туслах ганцаарчилсан үйлчилгээг нэг иргэнд, нэг цагт үзүүлэх зардал 6,000 төг, ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, сайжруулалтын чиглэлээр бүлгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх бол нэг иргэнд, нэг цагт ногдох зардал 3,500 төг байна.

1.6. Бизнес хөгжлийн байгууллага болон ХЭБ нь бичил бизнес эрхлэгчтэй ярилцаж, иргэнд үзүүлэх зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, энэхүү гэрээний хавсралтад тусгасны дагуу төлөвлөн хэрэгжүүлж, үр дүнг дүгнэнэ.

Хоёр. Бизнес хөгжлийн байгууллагын эрх, үүрэг

2.1. Бизнес хөгжлийн байгууллага дараах эрхтэй:

2.1.1. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний үр дүнг хангахын төлөө хамтран ажиллах, тодорхой цаг, хүчин чармайлт гаргахыг бичил бизнес эрхлэгчээс хүсэх,

2.1.2. Нэр бүхий сургалтын хөтөлбөрийг үйлчүүлэгчийн хэрэгцээнд нийцүүлж заах.

2.2. Бизнес хөгжлийн байгууллага дараах үүрэгтэй:

2.2.1. Бичил бизнес эрхлэгчийн хэрэгцээнд нийцсэн сургалт, зөвлөн туслах үйлчилгээний нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах,

2.2.2. Бичил бизнес эрхлэгчид үзүүлсэн санхүүгийн бус үйлчилгээг тухай бүр бүртгэж, үйлчилгээ авсан иргэнээр гарын үсэг зуруулан баримтжуулж байх,

2.2.3. Сургалт, зөвлөн туслах үйлчилгээг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, үйлчилгээний үр дүнг хангахын төлөө чармайж ажиллах,

2.2.4. Үйлчлүүлэгчийн суралцах явц, хичээл зүтгэлийг идэвхтэй дэмжиж ажиллах,

2.2.5. Бичил бизнес эрхлэгчийн зээлийн төслийн үйл ажиллагаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар мөрдөх, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөх,

2.2.6. Санхүүгийн бус үйлчилгээний талаар үйлчлүүлэгчдийн санал бодлыг сонсох, судлах, үйл ажиллагаандаа тусгах.

2.2.7. Үйлчилгээ үзүүлэх явцад олж мэдсэн үйлчлүүлэгчийн хувийн болон бизнесийн нууцыг хадгалах.

Гурав. Бичил бизнес эрхлэгчийн эрх, үүрэг

3.1. Бичил бизнес эрхлэгч дараах эрхтэй:

3.1.1. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх асуудлаар бизнес хөгжлийн байгууллагад санал дэвшүүлэх,

3.1.2. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний чанар, үр дүнгийн талаарх гомдлоо бизнес хөгжлийн байгууллагад болон\эсвэл харьяа аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бичгээр гаргах,

3.1.3. Бизнес хөгжлийн сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааны баримтжуулалтад өөрийн зүгээс хяналт тавих.

3.2. Бичил бизнес эрхлэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Бизнес хөгжлийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд зааж, зөвлөсөн мэдлэг, чадварыг эзэмшихийн төлөө чармайн суралцах,

3.2.2. Бизнесийн сургалт, үйлчилгээтэй холбогдуулан бизнесийн хөгжлийн байгууллагын дотоод журмыг хүндэтгэн мөрдөх, байгууллагын багш, ажилтнуудтай зөв, боловсон харьцах, хамтарч ажиллах,

3.2.3. Хүндэтгэх шалтгаанаар зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд үргэлжлүүлэн хамрагдах боломжгүй болсон бол энэ тухайгаа сургалтын байгууллагад бичгээр мэдэгдэх.

Дөрөв. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх, үүрэг

4.1 ХЭБ нь дараах эрхтэй:

4.1.1. Бизнес хөгжлийн байгууллагын үзүүлж буй зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний чанар, хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх,

4.1.2. Бичил бизнес эрхлэгч буюу үйлчлүүлэгчээс ирсэн холбогдох санал, гомдлыг судалж, шийдвэрлэх

4.1.3. Бизнес хөгжлийн байгууллага гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн гүйцэтгэхгүй байгаа нь нотлогдвол гэрээг дуусгавар болгох.

4.2. ХЭБ нь дараах үүрэгтэй:

4.2.1. Бизнес хөгжлийн байгууллагаас ирүүлсэн тайланг хүлээн авч, зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээний санхүүжилтийг үйлчилгээ авсан иргэний тоо, бодит зардалд үндэслэн шилжүүлж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах,

4.2.2. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдсан иргэн бүрээс сэтгэл ханамжийн судалгаа авах.

Тав. Бусад зүйл

5.1. Энэхүү гэрээ нь 20... оны .... сарын ....-ны өдрөөс 20...оны .... сарын ....-ны өдөр хүртэл хүчинтэй.

5.2. Бичил бизнес эрхлэгч тодорхой шалтгааны улмаас зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд хамрагдахаа зогсоовол энэхүү гэрээ дуусгавар болно.

5.3. Энэхүү гэрээг талууд гурван хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээний хувь бүр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

Гэрээ байгуулсан:

Сургалтын байгууллагыг төлөөлж:

.....
байгууллагын /захирал, менежер/
..... /гарын үсэг, тамга/
Хаяг:
.....хот\дүүргийн
.... .–р хорооны .....
.....
Цахим хаяг: .....
Утас: .....

Иргэн:

Овог .....
Нэр .....
РД: .....
Хаяг: ..... аймаг\дүүргийн
.....–р хорооны .....
Утас 1: .....
Утас 2: .....
Яаралтай тохиолдолд холбоо барих хүний утас: .....
...../гарын үсэг/

..... Аймаг/,
дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж:

..../гарын үсэг, тамга/
Албан тушаал:.....
Хаяг: .....
.....
Утас: .....

Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ авах иргэний хэрэгцээг тодорхойлох, үйлчилгээг төлөвлөх, үр дүнг дүгнэх маягт

<table>
<tr><td colspan="4">Нэг. Бичил бизнес эрхлэгчийн тухай суурь мэдээлэл</td></tr>
<tr><td colspan="2">Овог:.....
Нэр: .....

Регистрийн дугаар:
.....</td><td>Нас:

Хүйс:
1. Эр
2. Эм</td><td>Боловсролын түвшин:
1. Дээд болон түүнээс дээш
2. Мэргэжлийн боловсрол
3. Бүрэн дунд
4. Бүрэн бус дунд
5. Бага боловсрол
6. Бичиг үсэгт тайлагдсан, гэхдээ боловсрол эзэмшээгүй</td></tr>
<tr><td colspan="2">Үндсэн мэргэжил:

.....</td><td>Бичил бизнесийн чиглэл:

.....
.....</td><td>Бизнес эрхэлсэн нийт хугацаа:
.....
Жижиг зээл авсан бизнесийг эрхэлсэн хугацаа: .....</td></tr>
<tr><td colspan="4">Хоёр. Санхүүгийн бус үйлчилгээний хэрэгцээ</td></tr>
<tr><td rowspan="2">Өмнө нь бизнес хөгжлийн сургалтад хамрагдаж байсан эсэх</td><td>1. Тийм</td><td colspan="2">Ямар сургалтад хамрагдсан?
1. .....(сар/хоног)
2. .....(сар/хоног)
3. .....(сар/хоног)</td></tr>
<tr><td>2. Үгүй</td><td colspan="2"></td></tr>
<tr><td rowspan="2">Өмнө нь бизнесийн зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдаж байсан эсэх</td><td>1. Тийм</td><td colspan="2">Ямар үйлчилгээнд хамрагдсан?
1. .....(сар/хоног)
2. .....(сар/хоног)
3. .....(сар/хоног)</td></tr>
<tr><td>2. Үгүй</td><td colspan="2"></td></tr>
<tr><td>Бизнесээ хөгжүүлэх талаар дэвшүүлж буй зорилт</td><td colspan="3">1. .....

2.....</td></tr>
<tr><td rowspan="2">Бизнесээ эрхлэхэд тулгарч буй бэрхшээл</td><td>1.</td><td colspan="2">3.</td></tr>
<tr><td>2.</td><td colspan="2">4.</td></tr>
<tr><td colspan="4">Гурав. Санхүүгийн бус үйлчилгээний төлөвлөгөө</td></tr>
<tr><td>Санхүүгийн бус үйлчилгээнээс хүлээж буй үр дүн</td><td colspan="3">1.
2.
3.</td></tr>
<tr><td>Бизнес хөгжлийн сургалт</td><td colspan="3">Сургалтын чиглэл:
1. ..... (хоног/цаг)
2. ..... (хоног/цаг)
3. ..... (хоног/цаг)
4. ..... (хоног/цаг)
Нийт хоног: Нийт цаг:</td></tr>
<tr><td>Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ</td><td colspan="3">Үйлчилгээний чиглэл:
1. ..... (цаг)
2. ..... (цаг)
3. ..... (цаг)
4. ..... (цаг)
Нийт цаг:</td></tr>
<tr><td>Үйлчилгээ үзүүлэх хугацаа</td><td>20..... /..... / .....-нээс</td><td colspan="2">20..... /..... / ..... хүртэл</td></tr>
</table>

Дөрөв. Санхүүгийн бус үйлчилгээний үр дүнг үнэлэх хэсэг		
4.1. Бизнес хөгжлийн сургалтад хамрагдсан байдал		
Сургалтын нэр:	Хамрагдсан цаг:	Үр дүн: 1. 2. 3.
Сургалтын нэр:	Хамрагдсан цаг:	Үр дүн: 1. 2. 3.
Сургалтын нэр:	Хамрагдсан цаг:	Үр дүн: 1. 2. 3.
4.2. Бизнес хөгжлийн зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан байдал		
Үйлчилгээний чиглэл:	Хамрагдсан цаг:	Чухам ямар асуудалд анхаарсан болох: 1. 2. 3.
Үйлчилгээний чиглэл:	Хамрагдсан цаг:	Чухам ямар асуудалд анхаарсан болох: 1. 2. 3.
Үйлчилгээний чиглэл:	Хамрагдсан цаг:	Чухам ямар асуудалд анхаарсан болох: 1. 2. 3.
Тав. Бизнес хөгжлийн сургалт, зөвлөн туслах үйлчилгээний үр дүнд бичил бизнес эрхлэгчид бий болсон чадвар		
1. 2. 3. 4. 5.		
Сургалт, үйлчилгээ үзүүлсэн хугацаа	20..... /.... ./ .....-нээс	20..... /..... / ..... хүртэл
Үр дүнг үнэлсэн этгээд	**Нэр, гарын үсэг**	**Албан тушаал**
Аймаг, дүүргийн ХЭБ-аас:		
Бизнес хөгжлийн байгууллагаас:		
Үнэлгээ хийсэн огноо		
Зургаа. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ авсан иргэний дүгнэлт, санал, зөвлөмж		
1. Дээрх дүгнэлттэй **санал <u>бүрэн</u> нийлнэ.**	Учир нь: 1. 2. 3.	Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж: 1. 2. 3. **Гарын үсэг:** **Огноо:**
2. Дээрх дүгнэлттэй **санал <u>бүрэн нийлэхгүй</u>**.	Учир нь: 1. 2. 3.	

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 09 дүгээр сарын 26.-ны өдрийн 4/30 дугаар тушаалын аравдугаар хавсралт

Жижиг зээл авсан иргэдэд зориулсан санхүүгийн бус үйлчилгээний жишиг зардал

№	Санхүүгийн бус арга хэмжээ	Зардлын төрөл, хэмжээ /нэг хүнд/
1.	Бизнес хөгжлийн сургалт (ажлын 7 өдрийн сургалт)	1.1. Сургалтын зардал /нэг өдөрт/
		1 хүн = 8,500 төг
2.	Бизнесийн зөвлөн туслах үйлчилгээ (20 - 30 цаг)	2.1. Ганцаарчилсан зөвлөх үйлчилгээний зардал /нэг цагт/
		1 хүн = 6,000 төг
		2.2. Ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжүүлэлт, сайжруулалтын чиглэлээр бүлгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх зардал /нэг цагт/
		1 хүн = 3,500 төг

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн 359 дугаар тушаалын
арван нэгдүгээр хавсралт

Орон нутгийн санаачилгын төсөл хэрэгжүүлэх тухай гэрээний загвар

..... аймаг/дүүрэг №.... 20... оны .... сарын .... өдөр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.7 дугаар заалт, Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр"-ийн долоодугаар бүлгийг хэрэгжүүлэх зорилгоор нэг талаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ), нөгөө талаас ..... аймаг/нийслэл/дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага (цаашид орон нутгийн ХЭБ гэх) орон нутгийн зорилтот бүлгийн тогтвортой ажил эрхлэлтийг дэмжих зорилготой санаачилж, батлуулсан төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах зүйлийг тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Хот суурин газрын ажилгүйдлийг бууруулах, албан бус хэвшил дэх тогтворгүй, орлого багатай, баталгаа муутай ажил эрхлэлтийг илүү тогтвортой, баталгаатай ажил эрхлэлтэд шилжүүлэхийг дэмжих зорилгоор орон нутгийн ХЭБ-ын санаачлан боловсруулсан төсөл нь энэхүү гэрээний нэг хэсэг болно.

1.2. Төслийн санхүүжилт ..... /..... / төгрөг байна.

1.3. Төслийг 20..... оны .....-р сарын .....-нээс 20..... оны .....-р сарын .....-ны өдөр хүртэл нийт ..... сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

Хоёр. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын эрх, үүрэг

2.1. Төслийн хэрэгжилтэд арга зүйн удирдамж, зөвлөмж өгч хэрэгжилтийн явц, үр дүн, санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

2.2. Төслийн санхүүжилтийг орон нутгийн ХЭБ-ын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дэд дансанд дараах хуваарийн дагуу шилжүүлнэ. Үүнд:

2.2.1. Урьдчилгаа төлбөр (30%) буюу .....төгрөгийг гэрээнд гарын үсэг зурсны дараа,

2.2.2. Явцын төлбөр 1 (... %).....төгрөгийг төслийн хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг хүлээж авсны дараа,

2.2.3. Явцын төлбөр 2 (... %).....төгрөгийг төслийн хэрэгжилтийн хоёр дахь тайланг хүлээж авсны дараа,

2.2.4. Явцын төлбөр 3 (... %).....төгрөгийг төслийн хэрэгжилтийн гурав дахь тайланг хүлээж авсны дараа[71],

2.2.5. Эцсийн төлбөр (... %).....төгрөгийг төслийн хэрэгжилтийн эцсийн тайлан болон төслийн нэгдсэн тайланг хүлээж авсны дараа.

2.3. Орон нутгийн ХЭБ-аас төслийн үйл ажиллагааны тайланг цаг тухайд нь ирүүлэхийг шаардах, тайланд тусгагдсан мэдээллийг нягтлах, нэмэлт мэдээлэл хүсэх эрхтэй.

---

[71] Төслийн хугацааны мөчлөгийг харгалзан явцын төлбөрийн тоо, хэмжээг тодорхойлно.

2.4. Орон нутгийн ХЭБ гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй нь тогтоогдсон бол шаардлага тавих холбогдох арга хэмжээ аваагүй бол гэрээг цуцлах, төслийн санхүүжилтийг зогсоож, үр ашиггүй зарцуулсан хөрөнгийг буцаан татах эрхтэй.

Гурав. Орон нутгийн ХЭБ-ын эрх, үүрэг

3.1. Төслийн батлагдсан стратеги, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахгүйгээр төслийг хэрэгжүүлнэ.

3.2. Төслийн санхүүжилтийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулна.

3.3. Төслөөр туршигдсан ололт, үр нөлөөтэй арга хэмжээнүүдийн талаар туршлага хуваалцах, түгээн дэлгэрүүлэхэд хамтарч ажиллана.

3.4. Төслийг хэрэгжүүлэхдээ холбогдох эдийн засгийн салбар/мэргэжлийн төлөөллийн байгууллага, холбоо, ажил олгогч, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, төслийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.

3.5. Төслийн зорилго, үйл ажиллагаа, санхүүжилт, зарцуулалтын байдлыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад хэрэгслээр олон нийтэд нээлттэй, ил тод, тогтмол мэдээлнэ.

3.6. Төслийн арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйлчилгээ, арга хэмжээтэй уялдуулж хэрэгжүүлнэ.

3.7. Төслийн хэрэгжилтийн талаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дараах хугацаанд дагуу[72] ирүүлнэ:

3.7.1. Үйл ажиллагааны эхний тайланг төсөл хэрэгжиж эхэлснээс хойш зургаан сарын дараа буюу 20... оны .... сарын ....-ны өдрөөр тасалбар болгож, уг өдрөөс хойших нэг сарын дотор,

3.7.2. Үйл ажиллагааны 2 дахь тайланг төсөл хэрэгжиж эхэлснээс хойш арван хоёр сарын дараа буюу 20..... оны ..... сарын .....-ны өдрөөр тасалбар болгож, уг өдрөөс хойших нэг сарын дотор,

3.7.3. Үйл ажиллагааны 3 дахь тайланг төсөл хэрэгжиж эхэлснээс хойш арван найман сарын дараа буюу 20..... оны ..... сарын .....-ны өдрөөр тасалбар болгож, уг өдрөөс хойших нэг сарын дотор,

3.7.4. Үйл ажиллагааны эцсийн тайланг төсөл хэрэгжиж эхэлснээс хойш хорин дөрвөн сарын дараа буюу 20..... оны ..... сарын .....-ны өдрөөр тасалбар болгож, уг өдрөөс хойших хоёр сарын дотор,

3.7.5. Үйл ажиллагааны нэгдсэн тайланг төсөл хэрэгжиж эхэлснээс хойш хорин дөрвөн сарын дараа буюу 20..... оны ..... сарын .....-ны өдрөөр тасалбар болгож, уг өдрөөс хойш хоёр сарын дотор ирүүлнэ.

3.8 Төслийн үйл ажиллагааны нэгдсэн тайланг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, олон нийтэд ил тод танилцуулсан байна.

3.9. Орон нутгийн төсөл нь ажилгүйдлийг бууруулах шинэлэг арга хэмжээг туршиж, үр нөлөөг нь тогтоох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой тул орон нутгийн төслийн хэрэгжилтийг тайлагнахдаа үүнийг онцгойлон анхаарна.

3.10. Төслийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллана.

Гэрээ байгуулсан талууд:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрыг төлөөлж:

..../гарын үсэг, тамга/

Албан тушаал:.....

Хаяг: .....

Утас: .....

.....

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагыг төлөөлж газар, хэлтсийн дарга

..../гарын үсэг, тамга/

Албан тушаал:.....

Хаяг: .....

Утас: .....

[72] Төслийн хугацааг харгалзан тайлангийн тоо, хугацааг тодорхойлно.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 09 дүгээр сарын
26-ны өдрийн 1/3 дугаар тушаалын
арван хоёрдугаар хавсралт

Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын Хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдэд залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох тухай удирдамж

2006 оны 10 дугаар сарын 15 (2011 оны 1 дүгээр сард шинэчлэгдсэн)

Нэг. Удирдамжийн зорилго, ерөнхий зарчмууд

1.1. Энэхүү Удирдамж нь Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн Банк (ОУСБХБ) болон Олон улсын Хөгжлийн ассоциацийн (ОУХА) санхүүжилттэй хөрөнгө оруулалтын төслүүдийн бэлтгэл ажил, хэрэгжилтийн үеэр ОУСБХБ ба ОУХА-аас орж ирсэн санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох аливаа залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилготой. Энэхүү Удирдамжаар дамжуулан дээр дурьдсан хөрөнгийн эх үүсвэрийг хүлээн авч байгаа, дансанд байршуулах болон данс руу шилжүүлэх үүрэг хүлээсэн, тухайн эх үүсвэрийг ашиглах талаар шийдвэр гаргах эсвэл шийдвэрт нөлөөлөх этгээд, аж ахуйн нэгжүүдэд хамаарах ерөнхий зарчим, шаардлага болон хориг арга хэмжээнүүдийг тусгасан болно.

1.2. Дээр өгүүлсэн бүх этгээд, аж ахуйн нэгж нь ёс зүйн хамгийн өндөр хэм хэмжээг баримтлах ёстой. Дээрх бүх этгээд, аж ахуйн нэгж байгууллага нь залилан, авлигаас сэргийлэх, үүнтэй тэмцэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах, ОУСБХБ болон ОУХА-аас авсан санхүүжилтийг ашиглахтай холбоотой үүсч болох аливаа залилан, авлигын хэрэгт оролцохоос татгалзах үүргийг хүлээсэн болно.

Хоёр. Хууль эрх зүйн асуудлууд

2.1. Зээл авч, тодорхой нэгэн төслийг хэрэгжүүлэх үед тухайн Зээлд[73] хамаарах Зээлийн гэрээ[74] нь Зээлдэгч[75] ба Банкны[76] хоорондох хууль эрх зүйн харилцааг зохицуулна. Зээлийн гэрээний дагуу төслийг[77] хэрэгжүүлэх хариуцлага,

---

[73] Энэхүү Удирдамжид гарч байгаа "Зээлийн гэрээ"-нд ОУСБХБ-ны Зээлдэгч гишүүн орноос гаргаж байгаа баталгаатай холбогдох Батлан даалтын гэрээ, ОУХА-ын зээл эсвэл буцалтгүй тусламжид хамаарах Санхүүжилтийн гэрээ, төслийн бэлтгэл ажлыг хангах урьдчилгаа санхүүжилт олгох эсвэл Байгууллагын Хөгжлийн Сангаас (IDF) буцалтгүй тусламж олгох гэрээ, Итгэлцлийн сангийн буцалтгүй тусламжийн гэрээ, хүлээн авагч талын хэрэгжүүлэх буцалтгүй тусламж болон зээлийн гэрээ болон төсөл хэрэгжүүлэх байгууллагатай тохирсон Төслийн гэрээ зэрэг хамаарна.

[74] "Зээл" эсвэл "Зээлүүд" гэдэг нь энэхүү удирдамжаар зохицуулагдах төслүүдэд олгож байгаа буцалтгүй тусламж ба зээлүүдэд гэрээний дагуу олгож байгаа ОУСБХБ-ны зээл, ОУХА-ын зээл болон буцалтгүй тусламж, төслийн бэлтгэл ажлыг хангах урьдчилгаа санхүүжилт, Байгууллагын Хөгжлийн Сангийн буцалтгүй тусламж болон хүлээн авагч талын хэрэгжүүлэх буцалтгүй тусламж ба зээлүүдийг хамааруулна. Харин Банк Зээлдэгчтэй зээлийн эх үүсвэрийг юунд ашиглах талаарх тодорхой тохироогүй бол аливаа хөгжлийн бодлогын зээлд үүнд хамаарахгүй.

[75] Энэхүү Удирдамжид заасан "Зээлдэгчид" гэдэгт ОУХА-ын зээл, буцалтгүй тусламж, итгэлцлийн сангийн буцалтгүй тусламж, зээлийг хүлээн авч байгаа этгээдийг ойлгоно. Зарим тохиолдолд ОУСБХБ-ны Зээл нь Гишүүн улсаас өөр аль нэг этгээдэд олгогдож болно. Энэ тохиолдолд, тухайн нөхцөлд тусгайлан заагаагүй бол энэхүү Удирдамжид тусгасан "Зээлдэгч" гэдэгт Гишүүн орныг Зээлийн Батлан даагч гэж ойлгоно. Зарим тохиолдолд төсөл эсвэл төслийн аль нэгэн хэсгийг Банк Төслийн гэрээ байгуулсан Төсөл хэрэгжүүлэх этгээдээр гүйцэтгүүлэх боломжтой. Энэ тохиолдолд тус Удирдамжид заасан "Зээлдэгч" гэдэгт Зээлийн гэрээнд тусгасан Төсөл хэрэгжүүлэх этгээд мөн багтана.

[76] Энэхүү Удирдамжид заасан "Банк"-инд ОУСБХБ болон ОУХА нар хамаарна.

[77] Энэхүү Удирдамжид заасан "төсөл" гэдэгт Зээлийн гэрээнд тусгасан Төслийг хэлнэ.

Зээлийн хөрөнгийн ашиглалтыг Зээлдэгч хариуцна. Харин Банк нь өөрийн Дүрмийн дагуу "аливаа зээлийн хөрөнгийг зөвхөн тэр зээлийг олгосон зорилгын төлөө ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, хэмнэлт, үр ашгийн тал дээр анхаарч, улс төрийн болон эдийн засгийн бус нөлөө, бусад хүчин зүйлээс үл хамаарч ажиллана."[78] Энэхүү Удирдамж нь холбогдох харилцааг зохицуулахад нэн чухал хэсэг болж байгаа бөгөөд Зээлийн гэрээний дагуу төслийн бэлтгэл болон хэрэгжилтийн үе шатуудад хамаарна.

Гурав.Хэрэглэх хүрээ

3.1. Энэхүү Удирдамжийн зохицуулалтууд нь Банкны зүгээс бүхлээр нь эсвэл хэсэгчлэн санхүүжүүлсэн төслийн бэлтгэл ажил болон хэрэгжилтийн үед Зээлийн ашиглалттай холбоотойгоор гарч болох аливаа залилан, авлигын үйлдэлд хамаарна. Мөн тус Удирдамж нь Зээлийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд шууд ашиглах залилан, авлигын үйлдлүүдэд хамаарахын зэрэгцээ Зээлийн хөрөнгийн ашиглалтын талаарх шийдвэрт нөлөөлөх зорилгоор залилан, авлигын үйлдэл хийх зэргийг бас хамруулна. Энд дурьдсан бүх залилан, авлигын үйлдлүүд нь тус Удирдамжийн дагуу "Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотой гарсан" үйлдлүүдэд хамаатай юм.

3.2. Энэхүү Удирдамж нь Зээлийн хөрөнгийг өөрийн хэрэглээнд авч байгаа (тухайлбал эцсийн хэрэглэгч) Зээлдэгч, бусад этгээд болон байгууллагууд, Зээлийн хөрөнгийг байршуулах болон дамжуулах үүрэг бүхий санхүүгийн зууч гэх мэт этгээд (тэд өөрсдөө тус хөрөнгийн үр шим хүртэгч мөн эсэхээс үл хамаарна), мөн Зээлийн хөрөнгийн талаар шийдвэр гаргах эсвэл шийдвэрт нөлөөлж чадах этгээдүүд хамаарна. Энд дурьдсан бүх этгээдийг энэхүү хөрөнгийг биетээр эзэмшиж эсвэл үл эзэмшиж байгаагаас үл хамааран тус Удирдамжид "Зээлийн хөрөнгийг хүлээн авагчид" хэмээн тооцно.[79]

3.3. Банкнаас олгож байгаа Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн худалдан авсан эсвэл гүйцэтгүүлсэн бараа, ажил болон үйлчилгээний гэрээнүүдтэй холбоотой залилан, авлигын талаарх Банкны тодорхой журмын шаардлагуудыг Худалдан авах ажиллагааны журам[80] ба Зөвлөх сонгон шалгаруулах, ажиллуулах журамд[81]тус тус заасан болно. Худалдан авах ажиллагааны журам болон Зөвлөх сонгон шалгаруулах, ажиллуулах журмын заалтуудыг тодорхой зээлийн хүрээнд хэрэглэнэ.

Дөрөв. Залилан, авлигатай холбоотой үйлдлүүдийг тодорхойлох нэр томьёо

4.1. Энэхүү Удирдамжид зээлийн хөрөнгийг хүлээн авагч тал тус хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор гаргасан үйлдлүүдийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:[82]

---

[78] ОУСБХБ-ны Дүрмийн III-р зүйл, 5 дах хэсэг (b); ОУХА-ын Дүрэм, V-р зүйл, 1(g) хэсэг.

[79] Зарим хувь хүн, хуулийн этгээд 5 дах хэсэгт заасан ангиллуудын нэгээс олон ангилалд хамаарагдаж болно. Тухайлбал, санхүүгийн зууч байгууллага нь үзүүлсэн үйлчилгээнийхээ төлбөрийг авч, санхүүжилтийг эцсийн хэрэглэгчдэд шилжүүлэх гэхчлэн зээлийн хөрөнгийн талаар шийдвэр гаргах эсвэл аливаа шийдвэрт нөлөөлөх боломжтой.

[80] 2004 оны 5 сард батлагдаж 2006 оны 10 сар, 2010 оны 5 сард тус тус шинэчлэгдсэн *ОУСБХБ ба ОУХА-ын зээлээр худалдан авах ажиллагааны журам* мөн 2011 оны 1 сард батлагдсан *Дэлхийн Банкны зээлдэгчид ОУСБХБ ба ОУХА-ын зээл, буцалтгүй тусламжаар бараа, ажил болон зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах журам нь* үе үе шинэчлэгдэх боломжтой.

[81] 2004 оны 5 сард батлагдсан, 2006 оны 10 сард болон 2010 оны 5 сард тус тус шинэчлэгдсэн *Дэлхийн Банкны Зээлдэгч зөвлөх сонгон шалгаруулж, ажиллуулах журам,* 2011 оны 1 сард батлагдсан *ОУСБХБ-ны зээл болон ОУХА-ын зээл, буцалтгүй тусламжаар Дэлхийн Банкны Зээлдэгч Зөвлөх сонгон шалгаруулж, ажиллуулах тухай журам* нь үе үе шинэчлэгдэх боломжтой.

[82] Зээлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол Зээлийн гэрээнд энэхүү нэр томьёонуудыг ашиглах бүрт, мөн холбогдох Ерөнхий нөхцөлүүдэд ч хамаатуулан ашиглах үед энэхүү Удирдамжийн 7-р хэсэгт заасан утгатай адил болно.

a) Авлигын үйлдэл" гэж бусад талуудын[83] үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд шууд буюу шууд бус хэлбэрээр аливаа төрлийн үнэ бүхий зүйлийг санал болгох, өгөх, хүлээн авах, авахыг санаархахыг хэлнэ.

b)"Залилангийн үйлдэл" гэж санхүүгийн буюу бусад ашиг олох эсвэл үүрэг хариуцлагаас зугтахын тулд санаатай буюу санамсаргүйгээр[84] төөрөгдүүлэх эсвэл төрөгдүүлэхийг оролдох аливаа үйлдлийг хэлнэ.

c) "Хуйвалдах үйлдэл" гэж хоёр буюу түүнээс дээш талууд зүй бус зорилгод хүрэхээр үгсэн тохирох, түүний дотор бусад талуудын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэргийг хэлнэ.

d) "Дарамтлах үйлдэл" гэж нөгөө этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа этгээдэд буюу түүний эд хөрөнгөнд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулах, эсвэл хор хохирол учруулахаар заналхийлэхийг хэлнэ.

ЕСаад учруулах үйлдэл" гэж (i) Авлига, хууран мэхлэх, дарамтлах буюу хуйвалдах зэрэг үйлдлийн талаар гаргасан нэхэмжлэлээр Банкнаас хийж буй шалгалтанд зориудаар саад учруулах болон хяналт шалгалттай холбогдуулж мэдээлэл өгөхөөс татгалзах, хяналт шалгалтыг зогсоох үүднээс аливаа этгээдийг айлган сүрдүүлэх, дарамтлах, тавгүй байдалд оруулах, шалгалтын явцад нотолгоо болох баримт материалыг санаатайгаар устгах, хуурамч баримт үйлдэх, баримт материалыг орлуулах буюу нуун дарагдуулах болон шалгалт хийж буй хүмүүст худал мэдэгдэл хийх (ii) Банкны шалгалт болон хөндлөнгийн хяналт хийх явцад санаатайгаар саад учруулах зорилго бүхий үйлдлүүдийг хэлнэ[85].

4.2. Энэхүү Удирдамжид дээр өгүүлсэн үйлдлүүдийг нийтэд нь "залилан болон авлигын" үйлдлүүд хэмээн нэрлэсэн болно.

Тав. Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор залилан болон авлигаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ

5.1. Дээр дурьдсан зорилго, ерөнхий зарчмуудад хүрч ажиллахын тулд Зээлдэгч нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

(a) Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор үүсч болох авлигын, залилангийн, хуйвалдах, айлган сүрдүүлэх, болон саад учруулах аливаа үйлдлээс сэргийлэх зорилгоор зохих арга хэмжээг авах бөгөөд, үүнд (эдгээрээр хязгаарлагдахгүй) (i) Зээлийн хөрөнгийг Зээлийг анх авсан зорилгын дагуу ашиглах нөхцлийг хангахад чиглэсэн санхүүгийн хяналтын болон удирдлага зохион байгуулалтын зохицуулалт хийх, мөн (ii) төсөлд оролцож байгаа өөрийн бүх төлөөлөгчид[86], Төсөлтэй холбоотойгоор байгуулсан гэрээний аливаа харилцагч тал буюу Зээлийн хөрөнгийг хүлээн авч байгаа бүх этгээдэд энэхүү Удирдамжийн хувийг заавал хүргүүлж, түүний агуулгатай танилцуулах;

(b) Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор ямар нэг залилан, авлигын үйлдэл хийгдсэн тухай мэдээлэл ирмэгц Банкинд нэн даруй мэдээллэх;

(c) Хэрэв дээрх (a) хэсэгт дурьдсан хэн нэгэн этгээд, байгууллага Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор авлигын, залилангийн, хуйвалдах, айлган сүрдүүлэх, эсвэл саад учруулах үйлдэл гаргасныг Банк тогтоосон бол, тухайн асуудлыг шийдвэрлэхийн тулд Банкны шаардлагад нийцсэн зохих арга хэмжээг

---

[83] Авлигын үйлдлүүдэд хахууль өгөх, хууль бус үйл ажиллагааны төлөө шан харамж өгөх зэрэг багтана.

[84] "Санаатай буюу санамсаргүйгээр" үйлдэл хийх гэдэг нь залилан хийж байгаа тал өөрсдийн өгч буй мэдээлэл нь эсвэл төрүүлж буй ойлголт нь хуурамч гэдгийг мэдэж байх, эсвэл тухайн мэдээлэл нь үнэн эсвэл худал болохыг санаатайгаар огт тоохгүй байхыг хэлнэ. Энгийн хайхрамжгүй үйлдлийн улмаас мэдээллийг буруу өгөх, буруу ташуу ойлголт төрүүлэхийг залилангийн хэрэг гэж үзэхэд хангалтгүй юм.

[85] Эдгээр эрхэд бусад эрхийн зэрэгцээ доорх 9(d) хэсэгт багтсан эрхүүд мөн багтана.

[86] Энэхүү Удирдамжид дурьдсан байгууллагын "Төлөөлөгч" гэдэгт тухайн байгууллагын албан тушаалтан, албан хаагчид, ажилтнууд болон төлөөлөгчдийг багтана.

цаг тухайд нь авах;

(d) Банкны зүгээс Зээлийн хөрөнгийн ашиглалттай холбоотой харилцагч тал бүртэй байгуулах гэрээнд дараах заалтуудыг багтаасан (эдгээрээр хязгаарлагдахгүй) уг Удирдамжийг бүхэлд нь оруулж, мөрдүүлэх (i) энэхүү Удирдамжийн 10-р зүйлийг дагаж мөрдөхийг шаардах, (ii) Банкны зүгээс Зээлийн гэрээний дагуу хөтлөх ёстой тэдний санхүүгийн бүх данс тооцоо болон бусад баримт бичгийг шалгахыг зөвшөөрөхийг шаардах, мөн тэдгээрт Банкнаас эсвэл Банкны нэрийн өмнөөс хөндлөнгийн аудит хийлгэхийг зөвшөөрөх, (iii) Банкны зүгээс 11-р зүйлийн дагуу тухайн этгээдийг хууль бус үйлдэл хийсэн гэж үзсэн бол Зээлдэгчийн зүгээс түүнтэй байгуулсан гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, түдгэлзүүлэх; мөн (iv) залилан, авлигын үйлдлээр дамжуулан олж авсан зээлийн аливаа мөнгөн дүнг эргүүлэн төлөхийг шаардах;

(e) Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотой аливаа залилан, авлигын талаарх мэдээллийн дагуу мөрдөн шалгалт хийхэд Банкны төлөөлөгчидтэй бүх талаар хамтран ажиллах; мөн

(f) 11 зүйлд заасны дагуу Банкны зүгээс Зээлийн хөрөнгийг хүлээн авагч аль нэг этгээдийг хууль бус үйлдэл хийсэн хэмээн тооцвол, уг шийдвэрийг хүчин төгөлдөр хэрэгжүүлэхэд шаардлагатай, зохистой бүхий л арга хэмжээг авах, (i) Зээлдэгч ба тухайн этгээд хооронд байгуулсан гэрээг Зээлдэгч өөрт олгогдсон эрхийн дагуу хугацаанаас нь өмнө цуцлах эсвэл түдгэлзүүлэх ба/эсвэл (ii) хөрөнгийг буцаан төлүүлэх арга хэмжээ авах.

Зургаа. Зээлийн хөрөнгийг ашиглаж байгаа бусад талууд

6.1. Дээр дурьдсан зорилго, ерөнхий зарчмын шаардлагуудыг хангахын тулд Төсөлтэй холбоотойгоор Зээлдэгчтэй (эсвэл Зээлийн хөрөнгийг хүлээж авсан өөр этгээдтэй) гэрээ байгуулан ажиллаж байгаа Зээлийн хөрөнгийг хүлээн авагч аливаа этгээд дараах шаардлагыг хангана:

(a)Төсөлтэй холбоотой үйл ажиллагааг дээр дурьдсан ерөнхий зарчим, мөн 9(d) -р зүйлд тусгасан Зээлдэгчтэй байгуулсан гэрээний нөхцлүүдийн дагуу хийж гүйцэтгэхийн зэрэгцээ Зээлийн хөрөнгийг ашиглаж буй бусад аливаа этгээдтэй гэрээ байгуулахдаа дээрхтэй адил нөхцлүүдийг гэрээндээ тусгах;

(b)Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотой аливаа залилан, авлигын үйлдлийн талаарх мэдээ, мэдээлэл ирсэн бол Банкинд шууд мэдэгдэх;

(c)Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотой аливаа залилан, авлигын талаарх мэдээллийн талаар мөрдөн шалгалт хийхэд Банкны төлөөлөлтэй бүх талаар хамтран ажиллах;

(d)Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор өөрийн төлөөлөгч байгууллагын авлигын, залилангийн, дарамтлах, хуйвалдах ба саад учруулах аливаа үйлдлээс (хэрэв тийм зүйл гарвал) сэргийлэх бүх арга хэмжээг авах бөгөөд, үүнд (эдгээрээр хязгаарлагдахгүй) (i) Зээлийн хөрөнгийг Зээлийг анх авсан зорилгын дагуу ашиглах нөхцлийг хангахад чиглэсэн санхүүгийн хяналтын болон удирдлага зохион байгуулалтын зохицуулалт хийх, мөн (ii) холбогдох бүх этгээдэд энэхүү Удирдамжийн нэг хувийг заавал хүргүүлж, түүний агуулгатай танилцуулах;

(e)Холбогдох этгээдүүд дор дурьдсан 11-р хэсгийн дагуу хууль бус үйлдэл хийсэн нь тогтоогдвол, шаардлагатай бүх арга хэмжээг авч, тус төлөөлөгчийг төсөлтэй холбоотой бүх үүрэгт ажлаас нь чөлөөлж, Банкнаас шаардсан үед эсвэл бусад тодорхой нөхцөлд тухайн этгээдтэй байгуулсан гэрээний харилцаагаа бүр мөсөн зогсоох; мөн

(f)Дор дурьдсан 11 дэх зүйлийн дагуу холбогдох этгээд нь өөр нэг этгээд, байгууллагатай төслийн хүрээнд гэрээ байгуулж, уг тал нь хууль бус үйлдэл хийсэн нь тогтоогдсон бол, үүнийг бататгахад шаардлагатай бүх арга хэмжээг авахын зэрэгцээ, (i) тус гэрээг хугацаанаас нь өмнө зогсоох, түдгэлзүүлэх эрхээ хэрэгжүүлэх ба/эсвэл (ii) хөрөнгийг буцаан төлөхийг шаардах.

Долоо. Залилан болон авлигын эсрэг Банкнаас авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээ

7.1. Дээр дурьдсан зорилго, ерөнхий зарчмыг баримтлан ажиллах үүднээс Банк нь өөрийн Хориг тавих журмын дагуу хориг арга хэмжээ авах эрхтэй бөгөөд, Гишүүн орноос[87] бусад хувь хүн, хуулийн этгээдийг [88] гэрээ байгуулах эрхгүй болсныг (үүгээр хязгаарлагдахгүй) олон нийтэд тодорхой эсвэл тодорхойгүй хугацаагаар зарлаж, дараах эрхийг нь хязгаарлана: (i) Банкны санхүүжилттэй гэрээ байгуулах; (ii) Банкны санхүүжүүлсэн гэрээнээс санхүүгийн болон бусад хэлбэрээр үр шим хүртэх, тухайлбал туслан гүйцэтгэгч байх; мөн (iii) Банкнаас бүхэлд нь эсвэл хэсэгчлэн санхүүжүүлсэн төслийн бэлтгэл ажил, хэрэгжилтэнд оролцох. Ингэхдээ:

(a)Тус хувь хүн, хуулийн этгээд нь Зээлийн хөрөнгийг[89] ашиглахтай холбоотойгоор авлигын, залилангийн, хуйвалдах, дарамтлах болон саад учруулах үйлдэл хийхийг оролдсоныг Банк тогтоосон бол[90];

(b)Хориг тавих шийдвэрийг хамтран хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан бусад санхүүжүүлэгч байгууллага тухайн хувь хүн, хуулийн этгээдийг тус санхүүжүүлэгчийн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор авлига, залилан, хуйвалдах, дарамтлах, саад учруулах шинж чанартай үйлдэл хийснийг тогтоосон бол тухайн санхүүжүүлэгч байгууллагаас санхүүжилтийг авах эрхгүй эсвэл тухайн санхүүжүүлэгчийн бүрэн эсвэл хэсэгчлэн санхүүжүүлсэн төслийн бэлтгэл ажил, хэрэгжилтэнд оролцохгүй хэмээн мэдэгдсэн тохиолдолд; мөн

(c)Хэрэв Банкны Ерөнхий Үйлчилгээний Газар тухайн хувь хүн, хуулийн этгээдийг Дэлхийн Банкны Группын өөрийн хэрэгцээний худалдан авалттай холбоотойгоор залилан, авлигын үндэслэлээр хариуцлага алдсан хэмээн тооцсон бол.

Найм. Бусад

8.1. Энэхүү Удирдамжийн заалтууд нь Зээлийн гэрээний болон хоёр талын хооронд байгуулсан аливаа баримт бичгийн хүрээнд Банк эсвэл Зээлдэгчийн эдлэх бусад эрх, залруулах арга хэмжээ[91] болон хүлээх үүргийг хязгаарлахгүй.

---oOo---

---

[87] Тендерт санал ирүүлэхдээ хууран мэхлэх, авлигын үйлдэлд оролцсон хувь хүмүүс, хуулийн этгээдийг (тухайлбал Банкны санхүүжүүлсэн төсөлд санхүүгийн зууч байгууллага болон оролцохын тулд хуурамч бичиг баримт үйлдсэн банк гм) тендерт амжилттай оролцсон эсэхээс үл хамааран Банк тэдэнд хориг тавьж болно.

[88] Тус Удирдамжийн хувьд "Гишүүн орон" гэдэгт доорх үндэслэлээр тендерт оролцох эрхгүй улс төрийн болон төрийн захиргааны бүх шатны төрийн албан хаагч болон төрийн өмчит аж ахуйн нэгж, агентлагуудийг багтааж ойлгоно. Үүнд: (i) 2004 оны 5 сард батлагдаж 2006 оны 10 сар ба 2010 оны 5 сард тус тус шинэчлэгдсэн *ОУСБХБ-ны Зээл ба ОУХА-н зээлээр худалдан авалт хийх тухай журмын* 1.8(b) болон 2011 оны 1 сард батлагдсан *Дэлхийн Банкны Зээлдэгчид ОУСБХБ-ны Зээл ба ОУХА-н зээлээр бараа худалдан авах, ажил гүйцэтгүүлэх ба зөвлөхийн-бус үйлчилгээ авах тухай журмын* 1.10(b) эсвэл (ii) 2004 оны 5 сард батлагдаж 2006 оны 10 сар ба 2010 оны 5 сард тус тус шинэчлэгсэн *Дэлхийн Банкны Зээлдэгчид Зөвлөх сонгон шалгаруулах, ажиллуулах тухай журмын* 1.11(b) мөн 2011 оны 1 сард батлагдсан *Дэлхийн Банкны Зээлдэгчид ОУСБХБ-ны Зээл ба ОУХА-н зээлээр Зөвлөх сонгон шалгаруулж, ажиллуулах тухай журмын* 1.13(b).

[89] Банк нь Хоригийн Зөвлөлийг байгуулж, хоригтой холбоотой шийдвэрийг гаргах дүрэм журмыг баталсан болно. Хоригийн Зөвлөлийн журмууд нь Банкны ашиглаж болох бүх хоригийг багтаасан байдаг.

[90] Хориг арга хэмжээ нь холбогдох зээлийн аль нэг хэсгийг буцаан төлөхийг шаардахаар хязгаарлагдахгүй. Банк тус удирдамжийн 11-р зүйлийн дагуу гэрээ байгуулах эрхийг нь хязгаарлах шийдвэр гаргасан хувь хүн, хуулийн этгээдийг хэвлэл мэдээллээр зарлаж болно.

[91] Зээлийн гэрээ нь Зээлийн хөрөнгийг ашиглахтай холбоотойгоор залилан, авлигын үйлдэл нь тогтоогдсон тохиолдолд Банкинд Зээлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлж болох тодорхой эрх, залруулах арга хэмжээг зааж өгдөг.